

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 05

Рашаант

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2022 онд дэвшүүлсэн зорилт, Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн зөвлөмж чиглэлийг удирдлага болгон бүртгэлийн ажил үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах зорилтыг хангахын зэрэгцээ Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажилд онцгойлон анхаарал хандуулан ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтэс хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах, улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах, улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгуулах замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллав.

Мөн хэлтсийн нийт албан хаагчдад Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хуулийг чанд мөрдөн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үйлчилгээний стандартыг баримтлан ажиллахыг үүрэг болгон мэргэжлийн удирдлагаар ханган ажиллалаа.

Хэлтсийн 2022 оны жилийн эцсийн энэхүү тайланд хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулсан, байгууллагын стратеги зорилтыг хангах зорилгоор нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээнд хамрагдсан болон хэлтсийн хэмжээнд хийгдсэн ажил, улсын бүртгэгч нарын хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээг нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

- Хөтөлбөр ,төлөвлөгөөний хэрэгжилт;
- Удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын биелэлт;

- Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн нөхөн сонгуулийн бэлтгэл ажил, зохион байгуулалт
- Улсын бүртгэлийн (иргэнийн, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн) үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэх ажлын зохион байгуулалт;
- Бүртгэлийн хяналт;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн сайжруулалт;
- Санхүү, төсвийн удирдлага, төлөвлөлт болон төсвийн гүйцэтгэл;
- Байгууллагын дотоод ажил, үйл ажиллагааг сурталчлах ажиллагаа;
- Байгууллагын албан хаагчийн сургалт, хөгжил, ёс зүй;
- Орон нутаг дахь хамтын ажиллагаа;
- Идэвхи санаачилга, шинэлэг ажил

НЭГ.ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг УБЕГ-аас батлан ирүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд шаардлагатай тохиолдолд хэлтсээс дэд хөтөлбөр, төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

1.1.1. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийн хэрэгжилт;

1.1.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.3 Терроризмтэй тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.4 Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх дэд төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.5 Улсын бүртгэлийн байгууллагын жендэрийн нэгдсэн бодлогын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө

1.1.6 “УББ-ын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Дээрх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулах ажилтан, албан хаагчийг жил бүр өөрчлөн түүний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг хариуцсан ажилтнууд тус бүрээр гарган заасан хугацаанд тогтмол тайлагнаж байгаа болно.

Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх дэд төлөвлөгөөний хэрэгжилтийг иргэний улсын бүртгэгч Э.Адъяабаяр хариуцан хэрэгжүүлдэг ба

аймгийн ЗДТГ-т 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар хэрэгжилтийг гарган хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн байгууллагын жендэрийн нэгдсэн бодлогын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч А.Оюунсүвд хариуцан хэрэгжүүлж хэрэгжилтийг 2022 оны 11 дүгээр сарын сарын 29-ний өдөр gender@burtgel.gov.mn хаягаар цахимаар хүргүүлсэн.

ХОЁР. УДИРДЛАГААС ӨГСӨН ЧИГЛЭЛ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

Өнөө үеийн техник технологийн дэвшил, цахим орчны хэрэглээ, өөрчлөлт шинэчлэлт нь хууль тогтоомжийг улам бүр боловсронгуй болгон шинэчилж цаг үетэй хөл нийлүүлэх шаардлагыг бий болгож байна. “Нэг иргэн, нэг бүртгэл” хөтөлбөр ч үүнд зорьж батлагдсан бөгөөд бүртгэлийн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлэх, бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй бөгөөд ил тод, нээлттэй болгохоор тусгасан стратегийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгосон нь жил бүр биелэлээ олж буйг дурьдахад таатай байна.

2.1. Иргэний бүртгэлийн чиглэлээр

2.1.1 Ерөнхий газраас болон бусад байгууллагаас ирүүлсэн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтийн талаар:

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/134 тоот “Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг цахимжуулах тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/134 тоот “Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг цахимжуулах тухай” албан бичгийн дагуу **11 дүгээр сарын байдлаар** өссөн дүнгээр төрсний бүртгэл-6808, гэрлэсний бүртгэл-1958, гэрлэлт дуусгавар болсон бүртгэл-491, үрчилсний бүртгэл-246, эцэг эх тогтоосны бүртгэл-453, овог, эцэг эх, өөрийн нэр өөрчилсний бүртгэл-350, нас барсаны бүртгэл-1296, иргэний үнэмлэхний бүртгэл-2963, регистрийн дугаар өөрчлөлтийн бүртгэл 13, шилжилт хөдөлгөөн 6140, нийт **19837** хуудас холбогдох эх нотлох баримтуудыг цахимжуулсан ба тэдгээрийг хууль журамд зааснаар бүрэн гүйцэт, шаардлага хангасан байдлаар цахимжуулсан эсэх талаар мэдээллийн сангаас шалган, баталгаажуулж ажилласан. Дээрх бүртгэлийн ИУБ маягтын А талыг иргэний нэрийн эхний үсгээр галиглан, улсын бүртгэлийн нэгдсэн архивт, Б талыг тус хэлтсийн иргэний баримтын архивт хүлээлгэн өгч байршуулаад байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 4/522 тоот “Иргэний улсын бүртгэлийн тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

Улсын бүртгэл хөтлөх явцад тухайн иргэний улсын бүртгэлийн архивын эх нотлох баримт бичиг хоорондоо зөрүүгүй, зөвхөн цахим сангийн мэдээлэл зөрүүтэй бол иргэний улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулахаар холбогдох нотлох баримтыг ирүүлснийг үндэслэн иргэний улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэнэ гэсэн чиглэлийн дагуу нийт 191 удаагийн албан бичгээр 489 иргэний мэдээллийг архивын эх нотлох баримтын хамт иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж иргэний бүртгэлийн зөрчлийг арилгасан. Мөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичиг хоорондоо зөрүүтэй, иргэний улсын бүртгэлийн архив болон цахим мэдээллийн санд иргэний холбогдох мэдээлэл, эх нотлох баримт бичиг байхгүй, зөрүүтэй **127** иргэний албан хүсэлтийг төлөвлөж хяналтын байцаагчид хүргүүлэн шийдвэрлүүлсэн байна.

Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэмэлт өөрчлөлт оруулахаар хүргүүлж байгаа 439 иргэний хувийн хэрэг болон холбогдох хяналтын байцаагчийн дүгнэлтийг бүрэн цахимжуулсан.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10/789 дугаар албан бичгийн биелэлтийн талаар:

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10/789 тоот албан бичгээр **68** иргэний мэдээлэл ирүүлснээс тус хэлтсийн иргэний баримтын архивт хадгалагдаж байгаа 61 иргэний ИУБ-11 маягт 61 ширхэг, ИУБ-12 маягт 22 ширхэг, ИУБ-13 маягт 3 ширхэг, ИУБ-14 маягт 6 ширхэг нийт 92 ширхэг ИУБ маягтын Б талыг цахимжуулж ажиллав.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10/1536 дугаар албан бичгийн биелэлтийн талаар:

Лавлагааны тоон мэдээг чиглэлд тусгагдсан хугацаанд нь ya.munkhtulga@burtgel.gov.mn хаягаар, ИУБ маягтын А талыг эх хувиар нь нийт 11 удаа хүргүүлсэн байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1497 дугаар улсын байцаагчийн дүгнэлтийн биелэлтийн талаар:

Хяналтын улсын ахлах байцаагч Ч.Эрдэнэчимэгийн 2022.03.02-ны өдрийн 1497 тоот дүгнэлтийн дагуу 11 дүгээр сарын байдлаар нийт 2628 иргэний цахим

үнэмлэхийг Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хүчингүй төлөвт оруулж, дахин хэвлүүлж иргэнд олгож ажилласан.

Тус чиглэлд “Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 2, мөн зүйлийн 4-т заасан зөрчилд зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан эрх бүхий албан тушаалтны шийдвэрт үндэслэн иргэний үнэмлэхээ гээсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн иргэний үнэмлэхийг дахин олгохдоо цахим мэдээллийн санд бүртгэлтэй иргэний үнэмлэхийг хүчингүй болгоно” гэж заасан байгаа боловч хэлтсийн хяналтын улсын 2 байцаагч нь орон нутгийн прокуророос өгсөн чиглэлийн дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжгүй гэсэн тул тус гээсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн иргэний үнэмлэхийг ХУАБ-ийн 2022-03-02-ны өдрийн 1497 дүгнэлтээр хүчингүй болгон дахин олгож байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1543 тоот улсын байцаагчийн дүгнэлтийн талаар:

0-16 насны хүүхдийн төрсний бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах тухай Хяналтын улсын ахлах байцаагч Ч.Эрдэнэчимэгийн дүгнэлтийн дагуу 132 хүүхдийн бүртгэлийг архивийн цахим санд цахимжуулан, Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажиллалаа.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 4/2584 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 4/2584 тоот албан бичгийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг дуустал Баянхонгор аймагт 2020, 2021, 2022 онд бүртгэгдсэн нийт 7528 иргэний үнэмлэх анх удаа авсан болон 25, 45 насны сунгалт хийлгэсэн иргэдийн цээж зургийн стандарт болон бүртгэл үнэн зөв эсэх талаарх мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэг бүрчлэн нягтлан шалгаж дуусгасан. Үүнд:

1. 2020 онд 3410 иргэн иргэний үнэмлэх захиалснаас
 - Шинэ - 1275
 - Сунгалт - 2135
2. 2021 онд 3383 иргэн иргэний үнэмлэх захиалснаас
 - Шинэ – 1269
 - Сунгалт – 2164

3. 2022 онд 3 дугаар сарын 24-ний өдрийг дуустал нийт 735 иргэн иргэний үнэмлэх захиалснаас

- Шинэ – 290
- Сунгалт – 445 иргэний үнэмлэхийн бүртгэл тус тус бүртгэгдэж олгогдсон байна.

2020, 2021, 2022 онд бүртгэгдсэн бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нягтлан шалгах явцад зургийн стандартыг зөрчсөн, алдаатай бүртгэл илрээгүй. Харин Бэрсүт Баярсайхан Баянзул /вю05311531/ нь хөгжлийн бэрхшээлтэй учраас ганцаараа суух чадваргүй тул асран хамгаалагч нь хөдөлгөөнгүй байлгаж, зураг авхуулахаар толгойг нь гараараа түшиж зураг авахуулсан байна. Үүнийг зураг засвараар засаж, зургийн стандартаар иргэний үнэмлэхийг нь хэвлэж иргэнд нь олгосон. Уг ажлын талаарх илтгэх хуудсыг Иргэний улсын бүртгэлийн газар монгол шуудангаар цаасан хэлбэрээр, цахим шуудангаар b.otgon@burtgel.gov.mn хаяг руу хугацаанд нь хүргүүлсэн.

Монгол Улсын Хууль Зүй Дотоод Хэргийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 1/2502 тоот “дэмжлэг хүсэх тухай” албан бичиг

Улсын Их Хурлаас “Цахим гарын үсгийн тухай” хууль батлагдаж, 2022-05-01-ний өдрөөс эхлэн Монгол улсын 16 насанд хүрсэн иргэн бүрт Улсын бүртгэлийн байгууллагаас үнэ төлбөргүй цахим гарын үсэг олгох эрх зүйн орчин бүрдсэн талаар Баянхонгор аймгийн иргэдэд сурталчилан таниулж, аймгийн Номгон телевизээр мэдээлэл өгч ажиллав. Мөн аймгийн баганат талбайд “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулж нийт 318 тоон гарын үсэг олгосон.

Мөн төрийн байгууллагуудыг тоон гарын үсгээ авах талаар албан бичиг хүргүүлснээр “Баянхонгор – Эрчим хүч” ХХК, аймгийн Татварын хэлтэс, Цагдаагийн Газар, аймаг, сумын ЗДТГ-ын албан хаагчид, Нийгмийн даатгалын хэлтэс, Политехникийн коллеж, Баянхонгор сумын 1-4 дүгээр 10 жилийн сургууль, Алгоритм сургууль, ШШГГ, Прокурорын газар, Шүүх, Хууль, зүйн эрх хэлтэс, Архивын тасаг, Баянхонгор сумын 1-6 дугаар цэцэрлэг, зарим Өрхийн эмнэлгүүд гэх мэт байгууллагын албан хаагчид Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний танхимд ирж тоон гарын үсгээ авсан байна.

Мөн 1-10 дугаар Багийн Засаг дарга болон нийгмийн ажилтнуудад мэдээлэл өгч хуваарь гарган, багийн иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд КИОСК машинаар болон 24 улсын бүртгэгч, ахлах бүртгэгчийн хамт тоон гарын үсэг олголтыг хийж байна. Өнөөдрийн байдлаар

нийт **16924** тоон гарын үсэг олгосноос 15344 нь улсын бүртгэгчээс, **1580 нь КИОСК** машинаас тус тус олгогдсон байна.

Тоон гарын үсэг авсан иргэддээ цахим гарын үсгийн хэрэглээ, нууцлал, аюулгүй байдлыг хангах, нууцлалыг задруулж, алдсанаас үүсэх үр дагаврын талаар мэдээлэл зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.



Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 4/4585 тоот “Иргэний үнэмлэхийн бүртгэл хөтлөх тухай” биелэлтийн талаар:

Чиглэлд дурдсан Иргэний үнэмлэхийн бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлыг холбогдох хууль, журам, Засгийн газрын тогтоолын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус чиглэлийн 2022-05-25-ны өдөр хүлээн авч нийт улсын бүртгэгч нарт болон байгууллагын хамт олны хурал, шуурхай мэдээллийн цагаар танилцуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд өссөн дүнгээр 3417 иргэний үнэмлэхийн бүртгэл хөтлөгдөж, иргэдэд олголт хийсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 4/6527 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цахимаар бүртгэх үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia.mn/-д нэвтрүүлснээс хойш Баянхонгор аймгийн хэмжээнд 14 хүсэлт ирүүлснийг тухай бүрт нь шийдвэрлэж ажилласан. Нийт 14 хүсэлтээс 2 бүртгэл баталгаажсан, 11 хүсэлт татгалзсан, шалгагдсан 1 хүсэлт тус тус байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 1/7706 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

“Тоон гарын үсэг олгох ажиллагааг эрчимжүүлэх тухай” төлөвлөгөөг Хэлтсийн даргаас батлан иргэний улсын бүртгэлийн тасаг төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Тоон гарын үсэг хэрхэн хаанаас авах талаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын пэйж хуудсанд тавигдсан мэдээ, мэдээллийг хэлтсийн вэйб болон фэйсбүүк хуудсанд байршуулан түгээсэн. УБЕГ-аас ирүүлсэн хуваарийн дагуу Монгол улсын гавъяат багш, доктор Ш.Чимгээгээр Тоон гарын үсэг авахыг бүх нийтэд уриалсан бичлэгийг хийж, хугацаанд нь байршуулан олон нийтэд түгээсэн хандалт 6100 байна.

2. Баянхонгор аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудаар явж тоон гарын үсгийг олгож ажиллаж байна. /ШШГГ-ын албан хаагч, 2 хоригдол, орон нутгийн өмчит “Чандмань-Баянхонгор” ХК, Баруун бүсийн худалдааны төв, Төрийн банк, Статистикийн хэлтэс, Цагдаагийн газар, Өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар, цэцэрлэгүүд гэх мэт/

Тоон гарын үсэг авсан иргэддээ цахим гарын үсгийн хэрэглээ, нууцлал, аюулгүй байдлыг хангах, нууцлалыг задруулж, алдсанаас үүсэх үр дагаврын талаар мэдээлэл зөвлөгөөг тогтмол өгч өгч ажиллаж байна

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эрх зүйн хэлтсийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 3-1/7979 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

УБЕГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн 3-1/7979 албан бичигт дурдсан Эмнэлгийн байгууллагын албан хаагч нарт тоон гарын үсгийг олгож дууссан. Энэ ажлын хүрээнд Өлзийт сумын улсын бүртгэгчид хэрэглэгддэг зөөврийн сүлжээний тоног төхөөрөмжийг татан авч, аймгийн нийт Өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар зэрэг байгууллагуудын албан хаагчдад тухайн байгууллага дээр нь очиж тоон гарын үсэг олгосон. Эмч, эмнэлгийн албан хаагчид нийт 779 хамрагдсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 3/8181 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

Улсын бүртгэлийн ерөнхий газар нь үндэсний энгийн гадаад паспортын хэвлэлт хийх болсонтой холбогдуулан 2022 оны 10 дугаар сарын 3-ны өдрөөс 11-сарын 28-ны өдрийг дуустал нийт 351 гадаад паспортын захиалга авч, Төрийн банкны холбогдох дансанд **10,390,000** төгрөг төвлөрүүлэн ажилласан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/1194 тоот тушаал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын

2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 1/8275 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

Улсын бүртгэлийн байгууллагаас Үндэсний энгийн гадаад паспорт, хил орчмын нутагт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх олгох, гадаадад зорчих эрхийн бүртгэл хөтлөх журамд заасны дагуу бүртгэл хөтлөж, зургийн ямар нэгэн зөрчилгүй, бүрэн хэвлэгдэж, иргэдэд олгогдсон. Мөн хэвлэгдэн ирсэн 351 ш Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл хийснээс хэвлэгдэн ирсэн **218** паспортын Е дугаарыг Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тулган шалгаж иргэдэд олгосон. Холбогдох тушаал, чиглэлийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 4/9443 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

Тус чиглэлийн дагуу Гэрлэлт, Гэрлэлт дуусгавар, Шилжилт хөдөлгөөний бүртгэл, Биеийн давхцахгүй өгөгдлийн, Нас барсны, Цахим үнэмлэхний бүртгэлийн баталгаажилтыг хэрхэн яаж хийх талаар нийт улсын бүртгэгч нарт танхимаар сургалт зохион байгуулж, шаардлагатай тохиололд тухай бүрт нь утсаар зөвлөгөө өгч баталгаажилт хийлгэн, хяналт тавьж ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар Гэрлэлт 46, Гэрлэлт дуусгавар 4, Шилжилт хөдөлгөөний бүртгэл 108, Биеийн давхцахгүй өгөгдлийн 272, Нас барсны 33, Цахим үнэмлэхний 376 нийт 839 бүртгэл бүртгэж баталгаажуулсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 4/9698 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

Тус чиглэлийн дагуу 3 иргэний төрсний бүртгэлийн мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт оруулж, цахимжуулж ажилласан.

2.2.Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр

• ***“Чиглэл хүргүүлэх тухай” УБЕГ-ын дэд даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 2/1439 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн биелэлт;***

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг энэ онд улсын хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд орон нутагт ажиллах төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлын хэсгийг мэдээллээр хангах, зөрүүтэй бүртгэлийг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх асуудлаар зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг чиглэл болгосон ба уг чиглэлийн дагуу

аймгийн Орон нутгийн өмчийн албатай бүртгэл тулгах, зөрүүтэй бүртгэлийг улсын бүртгэлд бүртгүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

Тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам нь тус арга хэмжээний хүрээнд аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн А/102 тоот албан бичгээр ирүүлсэн 226 аж ахуйн нэгжийн нэр, регистрээр нэг бүрчлэн тулгалт хийж, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн судалгааг гарган 2022 оны 05 сарын 17-ны өдөр gbj.baatarogtokh@gmail.com хаяг руу, Хэлтсийн даргын 2022 оны 1/482 дугаарт албан бичгээр тус тус хүргүүлсэн бөгөөд улсын бүртгэлд бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн зөрүүтэй мэдээллийг залруулан улсын бүртгэлд бүртгүүлэх, бүртгүүлээгүй байгаа аж ахуйн нэгжүүд үл хөдлөх эд хөрөнгөө бүртгүүлэх арга хэмжээг 2022 оны 06 сарын 10-ны дотор шуурхай зохион байгуулахыг аймгийн ЗДТГ, Иргэний нисэхийн ерөнхий газрын харъяа “Баянхонгор аймгийн Нисэх буудал”, Баянхонгор аймгийн Шүүхийн Тамгын газар, Баянхонгор сумын Өрхийн эрүүл мэндийн төвүүд болон бусад төрийн байгууллагуудад анхааруулж, холбогдох чиглэл, зөвлөгөөг өгч, хамтран ажиллалаа.

- УБЕГ-ын даргын **2020 оны А/1172 дугаар тушаалаар** Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасан хаяж, үрэгдүүлсэн гэрчилгээг хүчингүйд тооцсон дүгнэлт гаргаж, шийдвэрлэх эрхийг хэрэгжүүлэхийг хяналтын улсын байцаагч нарт зөвшөөрсний дагуу хаяж, үрэгдүүлсэн гэрчилгээг дахин олгохтой холбоотой мэдүүлгийг хяналтын улсын байцаагчид хүсэлтийн хамт танилцуулан, улмаар дүгнэлт гаргуулж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн өмчлөх эрхийн гэрчилгээг дахин олгох бүртгэлийг хийж байна. Тайлант хугацаанд Хяналтын байцаагчийн **49 удаагийн дүгнэлтээр 49 гэрчилгээг дахин шинээр олгосон** байна.

Үрэгдүүлсэн гэрчилгээ дахин олгох уг бүртгэлийг **улсын бүртгэгч бүрийн** бүртгэсэн **бүртгэлийн тоогоор харуулбал**, Улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам 9, улсын бүртгэгч Т.Мягмарсүрэн 13, улсын бүртгэгч А.Оюунсүвд 20, улсын бүртгэгч Ё.Пүрэвдамба 7 бүртгэл тус тус хийсэн байна.

- УБЕГ-ын Тамгын газраас УБЕГ-ын **2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд** санал авахаар ирүүлсний дагуу уг төлөвлөгөөний төслийн 1.14-т **2 санал**, мөн төслийн 3 дугаар зорилтын хүрээнд нэмж, өөрчлөлт оруулах **2 санал**, нийт **4 саналыг** өгсөн ба эдгээр саналыг хэлтсийн даргын ts.munkhjargal@burtgel.gov.mn хаягаар дамжуулан хүргүүлсэн болно.

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг үнэн зөв хөтлөх зарчмыг хангах, алдаатай бүртгэл хийхээс урьдчилан сэргийлэх зорилгоор эд хөрөнгийн

эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх авсан Богд, Жаргалант, Хүрээмарал сумын улсын бүртгэгч нарт Газрын дундын мэдээллийн санд нэвтрэх, харах эрх олгохыг хүссэн хүсэлтээ Хэлтсийн даргын 2022 оны 1/531 тоот албан бичгээр ЭХЭУБГ-ийн даргад уламжлан танилцуулж шийдвэрлүүлснээр улсын бүртгэгч нар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхдөө газрын нэгж талбарын дугаар, газрын эрх, газар эзэмшигч, өмчлөгчийн мэдээлэл давхардсан эсэх талаар шалгах боломж бүрдэж, хууль, журмын хүрээнд бүрэн ашиглаж байна.

• **Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн /№2/ удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар;**

Хэлтсийн даргын үүрэг болгосноор улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам нь холбогдох албан тушаалтнаас саналыг авч нэгтгэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын удирдах ажилтны 12 дугаар шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн 9 дэх хэсэг “Улсын бүртгэлийн мэдээллийн санг үнэлж, дүгнэлт гарган, мэдээллийн санг цэгцлэх ажлыг иргэний бүртгэлийн төрлөөр эхлэн зохион байгуулах”, 15 дахь хэсэг “Улсын бүртгэлийн цахим шилжилтийн ажлын үр дүнгийн талаар тайлан ирүүлэх”, 17 дахь хэсэг “Иргэний улсын бүртгэл баталгаажуулалтын ажиллагааг сайжруулах асуудлыг судлан танилцуулах” зэрэг үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн 2022 оны 09 дүгээр сарын 12-нд “Илтгэх хуудас”-аар enkhnanan@burtgel.gov.mn хаягаар тайлагнасан байна.

3.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын бичгээр ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар:

• “Чиглэл хүргүүлэх тухай” ЭХЭУБГ-ын даргын 2022 оны 04 сарын 29-ны өдрийн 6/3763 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн биелэлт;

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргээс тусгаарласан баримтуудыг холбогдох журмын дагуу устгалд оруулах арга хэмжээ авч ажиллах чиглэлийг ирүүлсэн ба уг чиглэлд Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс тус ажлыг амжилттай сайн хийж хэрэгжүүлсэн байна гэсэн сайн жишээгээр дурьдагдсан. Учир нь, тус чиглэлийг ирүүлэхээс өмнө манай тасаг нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн цаасан суурьт баримтыг цахим сан дахь бүртгэлтэй нэг бүрчлэн тулган тоолох зарчмаар хувийн хэргийн тооллогын ажлыг 2021 оны 11, 12 сард зохион байгуулахдаа эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт /дотор/ тусгаарласан нотлох баримтуудыг салгаж, тусгаарлан 250 хуудас бүхий 965 нэгж бүхий хадгаламжийн баримтыг үүсгэсэн.

Уг хадгаламжийн баримт дээр нэмээд 2015 онд цахимжуулах явцад ангилан ялгаж тусгаарласан 392 нэгж бүхий хадгаламжийн баримтыг хамтад нь устгуулах арга хэмжээ авхуулахаар Хэлтсийн даргын 2022 оны 04 сарын 05-ны өдрийн 1/323 тоот албан бичгээр уламжлуулан ЭХЭУБГ-т танилцуулсан болно.

Тус арга хэмжээг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар одоогоор тодорхой хариу ирүүлээгүй байна.

- **ЭХЭУБГ-ын даргын 2022 оны 03 сарын 09-ний өдрийн 6/2010 тоот албан бичгээр** ирүүлсэн чиглэлийн биелэлт;

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлд заасан бүртгэл үнэн зөв, нотлох баримтад үндэслэх, хуульд заасан журмын дагуу бүртгэл хөтлөх зарчмыг хангах, зөрчлийг арилгах, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулах тухай хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1500 дугаарт дүгнэлтийг гаргасантай холбогдуулан ЭХЭУБГ-ын даргаас холбогдох чиглэлийг өгсөн билээ.

Уг чиглэлд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч хяналтын улсын ахлах байцаагчийн 1500 дугаарт дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системд засвар өөрчлөлт хийхийг чиглэл болгосон ба уг чиглэлийн дагуу өнөөдрийн байдлаар цахим санд **236 хувийн хэрэг, бүртгэлийг засаж залруулсан** бол харин 2021 оны 12 сард архивын тооллогын явцад илэрсэн **612 хувийн хэргээс 376** хувийн хэргийн бүртгэл, мэдээллийг цахим санд засаж, дахин цахимжуулсан байна.

- **“Чиглэл хүргүүлэх тухай” ЭХЭУБГ-ын даргын 2022 оны 05 сарын 30-ны өдрийн 6/4730 тоот албан бичгээр** ирүүлсэн чиглэлийн биелэлтийн талаар;

“Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийг хэрэглээнд нэвтрүүлэх” зорилтын хүрээнд **“Тушаалд өөрчлөлт оруулж, маягтын загвар батлах тухай”** УБЕГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/427 дугаар тушаалаар батлагдсан “Барьцааны гэрээ /ипотек/-г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт” /ЭУБ-06 маягт/, “Барьцааны гэрээ /ипотек/-ний нэмэлт, өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-13 маягт/-ээр барьцааны эрхийн бүртгэлийг улсын бүртгэлд бүртгэхээр болсон билээ.

Эдгээр маягтаар барьцааны эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх талаар орон нутгийн Банк, ББСБ-уудад холбогдох зөвлөгөө, мэргэжлийн арга зүйн

зөвлөгөө, туслалцааг өдөр тутамдаа өгч, аль болох иргэд чирэгдүүлэхгүй байх урьтдчилсан сэргийлэх арга хэмжээг өдөр тутамдаа авч ажиллаж байна.

Мөн тус маягт батлагдсанаас хойш 2022 оны 06 сарын 02-03-ны өдрүүдэд эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээний эрхийн бүртгэлийн мэдээг ЭХЭУБГ-аас 2022 оны 06 сарын 08-ны өдөр авсан ба уг судалгааг хугацаанд нь багтаан гарган хүргүүлсэн.

Тайлант хугацаанд буюу ЭУБ-06, ЭУБ-13 маягтыг хэрэглээнд нэвтрүүлж эхэлснээр /2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 30-ны хооронд/ **ЭУБ-06 маягтаар 1064, ЭУБ-13 маягтаар 76, нийт 1140** бүртгэл бүртгэгдэж, дунджаар **6545 хуудас цахимжсан** байна.

- **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас 2021 оны 03 сарын 16-ны өдрийн 7/1707, 2021 оны 03 сарын 29-ны өдрийн 1/2215, 2021 оны 04 сарын 14-ны өдрийн 7/2734** тоот албан бичгүүдээр холбогдох чиглэл, зөвлөмж ирүүлснийг улсын бүртгэгч нарт танилцуулж, нэг мөр ойлгон хэрэглэх, хэрэгжүүлэх талаар аргачилсан зөвлөгөө, зөвлөмжийг өгч, холбогдох сургалтыг 5 удаа зохион байгуулав.

- Хаягжуулалтын тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгө, гудамж, талбайг хаягжуулах журмын хүрээнд шинэчилэгдсэн хаягаар хийгдсэн кадастрын зураг, аймаг, сумын ИТХ-ын тогтоолыг үндэслэн газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн хаяг өөрчлөлтийн бүртгэлийг хийсэн ба уг бүртгэлтэй холбоотой бүртгэл, судалгааг улирлаар гарган ЭХЭУБГ-т edkhourungu@burtgel.gov.mn хаягаар хүргүүлж, танилцуулсан. Энэ оны 2 дугаар улирлын мэдээг 6 сарын 25-нд хүргүүлсэн.

- **ЭХЭУБГ-ын даргын 2022 оны 11 сарын 08-ны өдрийн 6/9582 тоот албан бичгээр** ирүүлсэн чиглэлийн биелэлт

“Хугацаатай үүрэг өгөх тухай” ЭХЭУБГ-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 6/9582 тоот албан бичгээр ирүүлсэн жагсаалтын дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичгээс зөрүүтэй, хуулийн этгээдийг иргэн төлөвтэй, хүчинтэй өмчлөгчийг барьцаалагчаар бүртгэсэн гэх мэт барьцаалагчийн мэдээлэл алдаатай бүртгэлийн **70 хувийн хэрэг**, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эд хөрөнгийн үнэ ороогүй газар болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн **14 хувийн хэрэг, бүртгэл** бүрийг эх нотлох баримт, цахим сантай тулган шалгаж алдааг засаж, холбогдох тайланг “Илтгэх хуудас”-аар epsr_akhlah@burtgel.gov.mn хаягаар 2022 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр илгээж тайлагнав.

2.3.Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

“Чиглэл хүргүүлэх тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 2/1439 тоот албан бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах ажлын хүрээнд Орон нутгийн өмчийн газартай хамтран ажиллах тухай 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/239 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын хуулийн этгээдийн бүртгэлийг шинэчилсэн бүртгэлд хамруулах талаар хамтран ажиллахаар аймгийн орон нутгийн өмчийн газраас хамтран ажиллах тухай албан бичиг, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй төрийн байгууллагуудын нэрийн жагсаалтыг ирүүлсний дагуу хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч, сумдын улсын бүртгэгч нартай хамтран төрийн байгууллагуудын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хариуцлагын хэлбэр, хаяг, удирдлага өөрчлөлтийн бүртгэлийг шинэчлэн бүртгэх ажлыг 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж ажилласан. 2022 оны 11 сарын 25-ны байдлаар нийт 119 төрийн байгууллага шинэчилсэн бүртгэлдээ хамрагдаад байна.

“Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг нөхөн бүртгэх тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2022 оны 04 сарын 26-ны өдрийн 1/3681 албан бичгийн биелэлтийн талаар:

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг нөхөн бүртгэлд бүртгүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах зорилгоор сумдын засаг дарга нар, сумдын улсын бүртгэгч нарт хэлтсийн даргын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 1/445 тоот албан бичгээр эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгэх ажилд хамтран ажиллах хүсэлт, хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн тухай ойлголт, түүнийг хэрхэн тогтоох, улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардлагатай баримтыг хэрхэн бүрдүүлэх талаарх аргачилсан зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн нөхөн бүртгэлийг тогтоосон хугацаанд бүртгэлд хамруулах талаар аймаг болон хөдөө орон нутгийн цахим мэдээллийн сүлжээ, хэлтсийн вэб сайт, facebook группт зар мэдээлэл байршуулж хэлтсийн нийт албан хаагчид шэйр хийж олон нийтэд түгээсэн.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллээ улсын бүртгэлд бүртгүүлээгүй нийт 846 хуулийн этгээд байгаагаас 2022 оны 11 сарын 25-ны

байдлаар нийт 196 хуулийн этгээд эцсийн өмчлөгчийн нөхөн бүртгэлдээ хамрагдсан байна. Тайланг УБЕГ-ын ХЭУБГ-т илтгэх хуудсаар Хуулийн этгээдийн цахим сангийн дотоод сүлжээний мэдээ, мэдээлэл тавьж хүргүүлэн ажилласан.

“Хоршоодыг шинэчилсэн бүртгэлд хамруулах тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2022 оны 05 сарын 17-ны өдрийн 5/4327 тоот албан бичгийн биелэлт:

Хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд бүртгэлтэй тус аймгийн харьяат нийт 246 хоршоодын судалгааг гаргаж тогтоосон хугацаанд эрчимтэй арга хэмжээ авч хоршоодыг шинэчилсэн бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулах талаар аймгийн ХХААГ-ын мэргэжилтэн Б.Оюунцэцэг болон сумдын хөдөө ахуйн мэргэжилтэнгүүд мөн сумдын улсын бүртгэгч нарт хэлтсийн даргын 2022 оны 05 сарын 09-ний өдрийн 1/446 тоот албан бичгээр чиглэл хүргүүлж хамтран ажилласан. Хоршооны шинэчилсэн бүртгэлийг тогтоосон хугацаанд бүртгэлд хамруулах талаар аймаг болон хөдөө орон нутгийн цахим мэдээллийн сүлжээ, хэлтсийн вэйб сайт, facebook группт зар мэдээлэл байршуулж хэлтсийн нийт албан хаагчид шэйр хийж олон нийтэд түгээсэн. Тайланг УБЕГ-ын ХЭУБГ-т илтгэх хуудсаар 2022 оны 06 сарын 02-ны өдрийн 1/527 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. 2022 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 85 хоршоо шинэчилсэн бүртгэлдээ хамрагдсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын ахлах бүртгэгч Ч.Батдэлгэрээс 2022 оны 10 сарын 26-ны өдөр ХЭУБГ-ын дундын чатаар “Архивт хувийн хэрэг нь байгаа шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн эдтээдийн судалгааг ирүүлэх тухай” чиглэлийн биелэлт:

Хуулийн этгээдийн бүртгэлийн архивт хувийн хэрэг нь хадгалагдаж байгаа шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн регистрийн дугаар, нэр, хэлбэрээр нь ангилан ялгаж судалгааг гарган 2022 оны 11 сарын 09-ний өдөр дотоод сүлжээний мэдээ мэдээлэлд байршуулж улсын ахлах бүртгэгч Ч.Батдэлгэрт хүргүүлэн ажилласан. Мөн хэлтсийн даргын албан тоотоор цаасан хэлбэрээр ХЭУБГ-т хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын ахлах бүртгэгч Ч.Батдэлгэрээс 2022 оны 11 сарын 09-ний өдөр хэлтсийн дотоод сүлжээ болох 100 шэйр дээр байршуулсан мэдээ мэдээллийн биелэлтийн талаар:

Тус мэдээлэлд хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд хуулийн этгээдүүдийн хөрөнгө, хувьцаа эзэмшигчийн тоо, хувь зөрсөн байх тул нэг бүрчлэн

шалгаад зөв болгох мэдээллийг гаргаж ирүүлнэ үү гэсэн үүрэг даалгаврын дагуу тус аймгийн харъяат 226 хуулийн этгээдийн нэрийн жагсаалтыг хүлээн авч 2022.11.25-ны өдрийн байдлаар 45 хуулийн этгээдийн архивын цаасан нотлох баримтыг архиваас татан авч цахим мэдээллийн санд мэдээлэл нэг бүрчлэн тулган шалгаж зөрүүтэй орсон мэдээлэл дээр тайлбар бичиж хуулийн этгээдийн цахим сангийн мэдээ мэдээлэл дээр байршуулан улсын ахлах бүртгэгч Ч.Батдэлгэрт хүргүүлсэн. Үлдсэн 181 хуулийн этгээдийн зөрүүтэй мэдээллийг шалгаж энэ онд багтаан хүргүүлэхээр ажиллаж байна.

2.4.Архивын чиглэлээр

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 10/05 тоот “Чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 10/05 дугаар чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай албан бичиг, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаартай Улсын бүртгэлийн хэлтсийн ББНШК-ын хурлын тэмдэглэлийн дагуу тус хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийн хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй, архивын санд хадгалах шаардлагагүй устгах баримтын жагсаалтын дагуу устгалыг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хийв. Үүнд:

1.Иргэний үнэмлэх дахин олголтын анкет, бүртгэлийн дэвтэр 2019 оны 18 хадгаламжийн нэгж 6586 хуудас,

2.Иргэний үнэмлэх дахин олголтын анкет, бүртгэлийн дэвтэр 2020-оны 10 хадгаламжийн нэгж 6100 хуудас.

3.Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас лавлагаа олголтын бүртгэл 2020 оны 3 хадгаламжийн нэгж 23 хуудас,

4.Иргэний үнэмлэх олгосон хуудас 2020-оны 4260 ширхэг маягт, нийт 31 ширхэг хадгаламжийн нэгж 12709 хуудас.

Баянхонгор аймгийн төрийн архивын тасгаас ирүүлсэн 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 2/20 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

Тус албан бичгийн дагуу сумын Засаг даргын Тамгын газарт ажиллаж буй улсын бүртгэгч нарын 2022 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгуулах баримтын саналыг нэг бүрчлэн гаргаж жагсаалт үйлдэн тасгийн болон хэлтсийн даргад танилцуулж хэлтсийн албан тоотоор 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр аймгийн Төрийн архивын тасагт хүргүүлсэн.

Архивын ерөнхий газрын 2022 оны 01/495 тоот албан бичгээр “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт”-ын төсөлд санал хүргүүлэх бичгийн биелэлтийн талаар:

“Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт”-ын төсөлд өгөх саналыг цахим хэлбэрээр 2022 оны 8 дугаар сарын 19-ний өдөр contact@burtgel.gov.mn хаягаар саналаа хүргүүлэн ажилласан.

**ГУРАВ. АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮГИЙН ИТХ-ЫН НӨХӨН
СОНГУУЛИЙН СОНГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ , ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

УБЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/284 тоот тушаал, УБЕГ-ын даргын 2022-05-10-ны өдрийн А/339 тушаал, УБЕГ-ын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 1/4383 тоот албан бичгүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

1.Баянхонгор аймгийн Өлзийт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06/04 тоот “Орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийн тов зарлах тухай”, мөн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06/14 тоот “Орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийн санал авах байрыг тогтоох тухай” тогтоолуудыг хугацаанд нь хүлээн авч, ИУБГ-т хүргүүлэн, санал авах байрыг бүртгэн ажилласан.

2.Баянхонгор аймгийн Өлзийт сумын Бийрийн уулзвар буюу 5-р баг, 3-17-5 дугаар хэсэгт Орон нутгийн ИТХ-ын нөхөн сонгуульд санал өгөх 407 сонгогчийн нэрийн жагсаалтыг Иргэний улсын бүртгэлийн хаягийн сантай тулган шалгаж ажилласан. Үүнээс “Түр хасав” тэмдэглэгээ хийгдсэн 2 иргэнийг шалгахад “Гадаадад 60 буюу түүнээс дээш хугацаагаар зорчиж байгаа нь үнэн байна. Нийт сонгогчдийг 100 хувь хэсэг оноож ажиллан илтгэх хуудсыг хүргүүлсэн.

3.Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2022 оны 04 сарын 19-ний А/284 дугаар “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох” тухай тушаалын дагуу Баянхонгор аймгийн Өлзийт сумын шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 04 дүгээр сарын 20-ны өдрөөс түр зогсоосон.

Энэ талаар Цахим гарын үсгийн тухай хууль, түүнтэй холбоотой дүрэм журмыг танилцуулах танхимын сургалтыг сумын бүртгэгч нарт 04 сарын 20-ны өдөр зохион байгуулж, нөхөн болон дахин сонгууль явуулахаар товлон зарласан 15 аймгийн 43 сум, 22 дүүргийн мэдээллийг өгч, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогссон тухай тушаалыг нийт улсын бүртгэгч нарт танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4.Тус сонгуулийн хэсгийн хороонд итгэмжлэгдсэн ажилтнаар иргэний улсын бүртгэгч Ц.Эрдэнэчимэгийг ажиллуулах зөвшөөрөл авахаар Тагнуулын хэлтэст холбогдох материалыг хүргүүлж, 2022 оны 05 дугаар сарын 13-ны 28/41 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Итгэмжлэгдсэн ажилтай гэрээ байгуулж, нууцын баталгааг гаргуулан авч ажиллаж байна.

5.Улсын бүртгэгч Р.Насанжаргалд Сонгогчийн нэрийн жагсаалт хэвлэх эрх нээлгэж, 2022-05-23-ны өдөр СНЖ-ыг 2 хувь хэвлэж, хэлтсийн дарга, улсын бүртгэгчээр баталгаажуулан, тухайн өдрөө Өлзийт сумд /аймгийн төвөөс 18 км зайд байрладаг/ очиж Сонгуулийн хэсгийн хорооны даргад 1 хувийг актаар хүлээлгэн өгсөн. Мөн 1 хувийг нь Өлзийт сумын улсын бүртгэгч буюу итгэмжлэгдсэн ажилтан Ц.Эрдэнэчимэгт хүлээлгэн өгч илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлсэн.

6. Сонгогчийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийг УБЕГ-аас ирүүлсэн хуваарийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 3-ны өдөр татан авч Тагнуулын байгууллагын хамгаалалтад хүлээлгэж өгсөн.

ДӨРӨВ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН (ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН) ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН ШУУРХАЙ, ЧАНАРТАЙ ХҮРГЭХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ;

Хэлтсийн хамт олон холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн бусад актууд болон байгууллагын үйлчилгээний стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчилж, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллалаа.

Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх эрх зүйн орчин, орчин үеийн мэдээлэл технологийн шаардлагад нийцсэн цахим үйлчилгээг хүргэх нөхцөл боломж улам бүр төгөлдөршиж байгааг тэмдэглэе.

4.1. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тус хэлтэс иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт **18755** бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэн, баталгаажуулсан байна.

Үүнд:

-төрсний бүртгэл 1526

-үрчилсний бүртгэл 23


-ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл 84

-эцэг /эх/ тогтоосны бүртгэл 102


- гэрлэсний бүртгэл 291
- гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 65
- нас барсны бүртгэл 433
- шилжин ирсний бүртгэл 1512 /насанд хүрээгүй хүүхдэдтэйгээ нийт **2952** иргэн/

- үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл 1137
- Иргэний үнэмлэх 3690
- лавлагаа 9465
- дахин олгосон гэрчилгээ 368
- регистрийн дугаар өөрчилсөн 13
- Засвар өөрчлөлтийн бүртгэл 26

Иргэний бүртгэлийн төрлөөр нь ангилан графикаар харьцуулан харуулбал:



2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 9465 лавлагаа олгосноос иргэнд 4448, албан хэрэгцээнд 3650, албан тоотор 1367 лавлагааг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан, мэдээлэл удирдах системд шалган, шаардлагатай тохиолдолд иргэний баримтын архиваас эх нотлох баримтыг татан авч тулгаж иргэдэд лавлагаа олгож байна.



ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Улсын бүртгэлийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаагаар улсын бүртгэлийн үйлчилгээг цахимаар авах зөвлөгөө мэдээллийг иргэдэд байнга өгч ажиллаж байна. 2022 онд E-Mongolia буюу цахимаар иргэний цахим үнэмлэх 8ш захиалсан, үндэсний энгийн гадаад паспорт 6 ширхэгийг захиалан хэвлэгдэн ирснийг иргэдэд нь бүрэн хүлээлгэн өгсөн байна.


Хэлтсийн цахим үйлчилгээний булангаар үйлчлүүлж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчид хөдөө сумдад цахимаар үйлчилгээ авах нөхцөл, бололцоо муу, өөрсдийн мэдлэг хомс байгаа зэргээ тайлбарлаж, цахим үйлчилгээний ач холбогдол үр дүнд талархаж, амар хялбар болж байгаад талархаж буйгаа илэрхийлж байна.

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН АРХИВЫН ТАЛААР


Иргэний баримтын архивын хувийн хэргийн санд 2022 оны 11 дүгээр сарын байдлаар:

- Хувийн хэргийн нэгдсэн санд 112955 хувийн хэрэг
- Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн санд 4753 ширхэг хадгаламжийн нэгж
- Үндэсний энгийн гадаад паспортын санд 155 ширхэг хадгаламжийн нэгж тус тус хадгалагдаж байна.

Улсын бүртгэгч нараас 2022 оны жилийн эцсийн байдлаар иргэний улсын бүртгэл хөтөлсөн нийт **10458** ширхэг ИУБ маягтыг “Архивт маягт хүлээлцэх бүртгэл” болон нэрийн жагсаалтын хамт хүлээн авч цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан, архивт хүлээн авч хувийн хэргийн нэгдсэн санд нэг бүрчлэн байршуулж хувийн хэргийн баяжилтыг хийж ажиллав. Үүнийг дараах графикаар дэлгэрэнгүй харуулбал:



Жилийн эцсийн байдлаар өөр аймаг, хотруу шилжин явсан нийт **3939** иргэний хувийн хэрэг, хаатр, маягтыг жагсаалтын хамт албан бичгээр хүргүүлж ажилласан байна. Тухайлбал:



Мэдээллийн санд мэдээлэл нь зөрүүтэй иргэдийн хувийн хэрэг, болон архивын цаасан эх нотлох баримттай тулгах шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтан Хэлтсийн дарга, Тасгийн дарга, Хяналтын улсын байцаагч, Улсын бүртгэгч нарт “Архиваас түр ашиглуулахаар олгосон иргэний баримтын бүртгэлийн дэвтэр”-ээр нийт 231 иргэний хувийн хэрэг, 313 ширхэг бүртгэлийн дэвтрийг архивын сангаас гаргаж, буцаан хүлээн авч санд байршуулан ажилласан.


Иргэний улсын бүртгэгч нараас 2021 онд хөтлөгдсөн бүртгэлийн дэвтэр, бүртгэл хийхэд бүрдүүлсэн баримт бичгийн бүрдүүлбэрийг архивт хүлээн авахдаа баримтын үдэлт, дугаарлалт, нүүр, ашиглалтын хуудас, дотоод товьёг, баталгааны хуудас, бүртгэгчийн гарын үсэг зэргийг нягтлан шалгаж нийт 510 ширхэг хадгаламжийн нэгжийг “2021 оны бүртгэл, нотлох баримт хүлээлцэх” жагсаалтаар ХУУЛИЙН ХУГАЦААНД НЬ архивт хүлээн авч хаягжуулж, хадгаламжийн нэгж үүсгэн тавиурт байршууллаа.

4.2. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ:

1. Хуулийн этгээдийн бүртгэлийн талаар

2022 оны 11 сарын 25-ны байдлаар хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ авахаар ирсэн иргэн, аж ахуй нэгжид дараах бүртгэл үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Шинээр бүртгэгдсэн хуулийн этгээдийн улсын бүртгэл 197, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл 508, энэ онд бүртгэгдсэн хуулийн этгээдийн бүртгэлийн төрлийг дараах графикаар дэлгэрэнгүй харуулбал: Үүнд:



Хуулийн этгээдийн нотлох баримтын цахимжуулалтыг тухай бүрт цахимжуулж цаасан нотлох баримтыг УБЕГ-ын даргын 2019 оны А/1050 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан бүртгэлийн дагуу архивчид нийт 910 баримт материал хүлээлгэн өгсөн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны тайлан мэдээг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон тухай бүрт нь хугацаанд хүргүүлсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нэгдсэн мэдээг 11 удаа, улсын бүртгэлийн үйлчилгээний орлогын мэдээг 11 удаа, хуулийн этгээдийн архивын мэдээг 11 удаа гарган g.khuchitbaatar@burtgel.gov.mn хаягаар хүргүүлсэн. Үнэт цаасны мэдээг 11 удаа гарган хэлтсийн нярав, нягтлан нарт хүлээлгэн өгсөн.

Улсын бүртгэлийн байгууллагаас хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой дэлгэрэнгүй лавлагаа, хуулбар олгох, мэдээлэл өгсөн талаар:

Хуулийн этгээдийн лавлагаа 71 үүнээс иргэн, хуулийн этгээдэд 55, төрийн байгууллагад 16, хуулбар 44, үүнээс иргэн хуулийн этгээдэд 34, төрийн байгууллагад 10 олгосон байна.

Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой аж ахуй нэгжийн мэдээллийг төрийн байгууллагад нийт 9 удаа хүргүүлсэн. Үүнээс: Баянхонгор аймаг дахь худалдаа аж үйлдвэрийн танхимд-1 удаа, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт-1 удаа, Нийгмийн даатгалын хэлтэст-1 удаа, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2 удаа, аймгийн орон нутгийн өмчийн газарт- 2 удаа, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт-2 удаа тус тус хүргүүлэн ажилласан.

Тамга тэмдгийн хяналтын дугаар олгосон нийт 278 бүртгэл бүртгэсэн байна. Хуулийн этгээдийн элэгдэж хуучирсан, ашиглах боломжгүй тамга тэмдгийн хураан авах, хяналтын дугаар дахин олгох, хаяж үрэгдүүлсэн тамга тэмдэг, хяналтын дугаарыг дахин олгох, татан буугдсан, хэлбэр, нэр өөрчлөгдсөн хуулийн этгээдийн тамга тэмдэг нийт 21 ширхэгийг хураан авч жилийн эцсийн байдлаар буюу 2022.12.30 -ний өдөр устгалыг хийхээр ажиллаж байна. Мөн Төрийн байгууллагын 3 ширхэг тамга, тэмдгийг хураан авсан. 2022.12.15- ны өдөр холбогдох журмын дагуу төрийн архивын тасагт шилжүүлнэ.

Хуулийн этгээдийн оноосон нэрийг баталгаажуулан бүртгэлийг хөтлөж 2022.11.25-ны байдлаар нийт 995 үүнээс биечлэн ирсэн 175, e.mongolias 820 хүсэлт хүлээн авч, зөвшөөрсөн 119, татгалзсан 651, баталсан 50 нэрийн баталгаажилтын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Хуулийн этгээдийн мэдээлэл улсын бүртгэлийн мэдээллийн санд зөрүүтэй орсонтой холбоотой иргэн, хуулийн этгээдээс нийт 12 удаагийн хүсэлтийг хүлээн авч зөрчлийг арилгуулахаар ХЭУБГазар болон хэлтсийн хяналтын улсын байцаагч нарт хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Хоршооны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хоршоодыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд хамруулах, мөн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах зорилтын хүрээнд;

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн Тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Отгонсүрэн нар Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран Хоршооны шинэчилсэн хуулийн үзэл баримтлал, тус хуульд орсон зарчмын томоохон өөрчлөлтийг танилцуулах, Хоршоодыг шинэчилсэн бүртгэлд хамруулахтай холбоотойгоор анхаарах асуудал, улсын бүртгэлд шуурхай хамрагдах талаар мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх зорилго бүхий “Хоршоодыг чадавхижуулах” сургалтыг 2022 оны 03 сарын 25 өдөр зохион байгууллаа.

Тус сургалтанд сум бүрээс нэг хоршоо, нийт 20 хоршооны удирдлага оролцсон байна.

2.Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын чиглэлээр:

Хуулийн этгээдийн бүртгэлийн архивт нийт 2602 ширхэг хувийн хэрэг хадгалагдаж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2019 оны А/1050 дугаар тушаалын 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлсэн жагсаалт"-аар 197 ширхэг шинэ хувийн хэрэг, "Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт"-аар 508 ширхэг нотлох баримт материал хүлээн авч хувийн хэрэг тус бүрт нэгтгэн байршуулж хувийн хэргийн баяжилт, хаягжуулалт хийсэн.

4.3. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2022 онд дэвшүүлсэн зорилт, Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн зөвлөмж чиглэлийг удирдлага болгон Улсын бүртгэлийн багц хуулийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарал хандуулан ажиллалаа.

Тасгийн хувьд Улсын бүртгэлийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын

бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах, улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах, улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү тайланд хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг болон хэрхэн зохион байгуулсан, байгууллагын стратеги зорилтыг хангах, нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээнд хамрагдсан болон тасгийн хэмжээнд хийгдсэн ажил, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцөл боломжоор хангах, улсын бүртгэгч нарын хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээг нэгтгэн танилцуулж байна.

Нэг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Манай тасгийн хамт олон холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн бусад актууд болон байгууллагын үйлчилгээний стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчилж, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллалаа.

Хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах замаар бүртгэлийн эрх зүйн орчныг сайжруулах, төгөлдөршүүлэх зорилтыг хангах зорилгоор **УБЕГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.14-д “Улсын бүртгэл хөтлөхтэй холбоотой дүрэм, журмын төслийг боловсруулж, батлах, эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх”** ажил үйлчилгээ оруулсан байна. Энэ ажлын хүрээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй **“Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг цахим систем /ePRS/-д хөтлөх журам”**-ыг шинэчлэхээр хэлэлцүүлсэн төсөлд **9 саналыг**, мөн тус журмын төсөлтэй холбогдуулан **“ePRS-II” системд нэмэлт өөрчлөлт оруулах**” талаар **7 саналыг, нийт 16 саналыг** edkhourunqu@burtgel.gov.mn хаягаар 2022 оны 05 дугаар сарын 02-нд хүргүүлсэн байна. Хэлэлцэгдэж буй уг журмын төсөлд улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам, улсын бүртгэгч Т.Мягмарсүрэн, А.Оюунсүвд нар саналаа өгсөн байна. (Хавсралт-1)

а. Шинэчилэн боловсруулах шаардлагатай хууль тогтоомжийн хэлэлцүүлэг, санал асуулгын хүрээнд УБЕГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 3/7450 дугаарт албан бичгийн дагуу **“Эд хөрөнгийн эрхийн улсын**

бүртгэлийн тухай хууль”-ийн 3 дугаар зүйлд 1 санал, 9 дүгээр зүйлд 2 санал, 10 дугаар зүйлд 2 санал, 13 дугаар зүйлд 1 санал, 21 дүгээр зүйлд 1 санал, **“Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”**-ийн 10 дугаар зүйлд 2 санал, 18 дугаар зүйлд 1 санал, **“Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам”**-ын 3 дугаар зүйлд 1 санал, 5 дугаар зүйлд 1 санал, 11 дүгээр зүйлд 2 санал, **нийт 14 санал**, харин **шинээр боловсруулах шаардлагатай хууль тогтоомжийн хувьд** **“Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэх журам”, “Цахим системд хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хөтлөх журам”**–ыг шинээр боловсруулах хэрэгцээ, шаардлага байгаа талаар **нийт 2 санал**, тайлбарын хамт 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр enkhjin@burtgel.gov.mn хаяг руу хүргүүлсэн болно. (Хавсралт-2)

1.3. Цахим гарын үсгийн тухай хуульд зааснаар Улсын бүртгэлийн байгууллагаас 16-аас дээш насны иргэдэд тоон гарын үсэг олгох болсонтой холбогдуулан **“Монгол улсын иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам”**-ын төслийг хэлэлцүүлсэн ба уг журмын төсөлд улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам 1 санал, асуулга бичсэн ба уг саналыг холбогдо хаягаар хүргүүлсэн.

1.4. **“Тушаалд өөрчлөлт оруулж, маягтын загвар батлах тухай”** УБЕГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/427 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ирүүлсэн ЭХЭУБГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн **6/4730 дугаарт** болон 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн **6/7670 дугаарт** албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу “Барьцааны гэрээ /ипотек/-г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-06 маягт/, “Барьцааны гэрээ /ипотек/-ний нэмэлт, өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-13 маягт/-ээр барьцааны гэрээ, барьцааны гэрээний нэмэлт өөрчлөлтийн гэрээг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн бүртгэж эхэлсэн.


2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 30-ны хооронд **ЭУБ-06 маягтаар 1064, ЭУБ-13 маягтаар 76, нийт 1140** бүртгэл бүртгэгдэж, **6545 хуудас цахимжсан** байна. **Харьцуулалт хийж үзэхэд**, 2022 оны 05 сарын 16-наас 05 сарын 31-ны хооронд гэрээгээр 120 бүртгэл хийгдэж 1842 хуудас цахимжиж байсан байх ба нэг бүртгэлийн хуудасны тоо дунджаар 15,35 хуудас цахимждаг байсан байна. Ийнхүү цахим мэдээллийн санд орох цаасны хэмжээг бууруулснаар цахим сангийн багтаамжийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд, мөн

цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдол бүхий ажил болж байна.

1.5. УБЕГ-аас “Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд нийт албан хаагчдаас авсан саналын хүрээнд тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхамын зүгээс “Хяналтын улсын байцаагчийн ажлын байрны тодорхойлолт”-д “албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг” хэсэгт бичигдсэн чиг үүргүүд нь “Албан тушаалын зорилт” хэсгийн 2 дахь зорилтын томъёололтой агуулгын хувьд нийцэхгүй байна гэж үзэн өөрчлөн томъёолох талаар, мөн “Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн ажлын байрны тодорхойлолт”-д тухайн албан тушаалд тавигдах мэргэжлийн шаардлагад “Эрх зүйч” гэж заах нь чухал талаар саналаа тайлбарын хамт 2022 оны 06 дугаар сарын 15-нд хэлтсийн даргын ts.munkhjargal@burtgel.gov.mn хаягаар дамжуулан танилцуулсан байна. (Хавсралт-3)

1.6. Хаягжуулалтын тухай хууль болон УБЕГ-ын стратеги хөтөлбөр, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасан “Газрын мэдээллийн болон хаягийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг Улсын бүртгэлийн мэдээллийн сантай холбох, эдгээр сангийн мэдээлэлд суурилсан хаягийн мэдээллийн сан үүсгэх, өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлэх.” ажлын бэлтгэл ажлыг хангах, эд хөрөнгийн хаягийн өөрчлөлтийн бүртгэлийг эрхийн улсын бүртгэлд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн хөдөө сумуудын нутаг дэвсгэрт оршин байгаа үл хөдлөх эд хөрөнгийн хуучин хаягийг шинэ хаягтай тулган бүртгэл, судалгаа хийх ажлын Удирдамжийг боловсруулан Хэлтсийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 1/414 тоот албан бичгээр сумдын Засаг дарга нарт хүргүүлж, бүртгэл судалгаа хийх ажлыг 2022 оны 05 дугаар сарын 01-20-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Энэ ажлын хүрээнд сумын ЗДТГ-ын дарга, багийн Засаг дарга, газрын даамал, татварын байцаагч нарыг татан оролцуулах чиглэлийг өгч хамтран ажиллав. Уг бүртгэл, судалгааны үр дүнд хөдөө сумдад оршин байгаа үл хөдлөх эд хөрөнгүүдийн хаягийн өөрчлөлтийг улсын бүртгэлд хамруулах, улмаар үл хөдлөх эд



хөрөнгийн хаягийн мэдээллийн санг хаягийн зөв мэдээллээр баяжуулалт хийх ажлууд хийгдэж байна.

Хоёр. Цахим шилжилтийн ажлын талаар:

2.1. “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх ажлыг үе шаттайгаар хийх ажлыг үргэлжлүүлэх” зорилтын хүрээнд:

✓ ЭХЭУБГ-ын даргын 2022 оны 04 сарын дотоод албан бичгээр ирүүлсэн албан даалгавар, түүнийг гүйцэтгэх “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт үзлэг хийх ажлын удирдамж”-ийн хуваарилсан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн **Y-0320006383-аас Y-0320006582** хүртэлх дугаарт бүхий нийт 200 хувийн хэрэгт үзлэгийг заасан хугацаанд багтаан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам хийж гүйцэтгэлээ.

Жагсаалтын дагуу үзлэгт хамрагдсан **200 хувийн хэргийн 395 бүртгэл, 8037** хуудас бүхий нотлох баримтыг **тулган нягтлаж, тайланг** хэлтсийн даргын гарын үсгээр албажуулан хуулийн хугацаанд нь багтаан z.gantsetseg@burtgel.gov.mn хаяг руу илгээж тайлагнав.

✓ Мөн “Хугацаатай үүрэг өгөх тухай” ЭХЭУБГ-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 6/9582 тоот албан бичгээр ирүүлсэн жагсаалтын дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичгээс зөрүүтэй, хуулийн этгээдийг иргэн төлөвтэй, хүчинтэй өмчлөгчийг барьцаалагчаар бүртгэсэн гэх мэт барьцаалагчийн мэдээлэл алдаатай гэх 70 бүртгэлийн, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эд хөрөнгийн үнэ ороогүй гэх 14 бүртгэлийг эх нотлох баримт, цахим сантай тулган шалгаж алдааг засаж, eprs_akhlah@burtgel.gov.mn хаягаар 2022 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр илгээж тайлагналаа.

✓ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд алдаатай, буруу орсон бүртгэлүүдийг бүртгэл хийх явцад илэрсэн, мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн бүртгэл, маягтын архивын баяжилт хийх явцад илэрсэн алдаатай бөгөөд буруу орсон бүртгэлүүдийг УБЕГ-ын ХШГ-ын хяналтын улсын байцаагчийн 1500 дугаарт дүгнэлтээр, хэлтсийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр, мөн ЭХЭУГ-аас ирүүлсэн тухайн бүрт нь цахим санд засаж, дахин цахимжуулах арга хэмжээ авч байна. Энэ ажлын хүрээнд өнөөдрийн байдлаар цахим санд 236 хувийн хэрэг, бүртгэлийг засаж залруулсан бол харин 2021 оны 12 сард архивын тооллогын явцад илэрсэн 612 хувийн хэргээс 376 хувийн хэргийн бүртгэл, мэдээллийг цахим санд засаж, дахин цахимжуулсан байна. Харин

Хяналтын улсын байцаагчийн 8 удаагийн дүгнэлтээр 18 хувийн хэрэг бүртгэлийг эх нотлох баримт болон цахим сантай тулган цахим санд засвар өөрчлөлт хийж бүртгэл үнэн зөв байх зарчмыг хангалаа.

2.2. “Сум, хорооноос эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд УБЕГ-ын даргын 2021 оны Б/701 тоот тушаалаар Богд, Хүрээмарал сумын улсын бүртгэгч нарт, УБЕГ-ын даргын 2022 оны Б/197 тоот тушаалаар Жаргалант сумын улсын бүртгэгч Т.Алтаншагайд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгуулж, ЭХЭУБГ-ын даргын 2022 оны 6/334 дугаарт албан бичгээр ирсэн “Чиглэл”-ийн дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт 20 хоногийн дадлага хийлгэж, мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллалаа. Жаргалант, Богд, Хүрээмарал сумдын улсын бүртгэгч нар тайлант хугацаанд **нийт 479 мэдүүлэг хүлээн авч** /газар-280, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө-199/ хуулийн хугацаанд багтаан шийдвэрлэсэн байна. **Улсын бүртгэгч бүрээр хийсэн бүртгэлийн тоог харуулбал**, Жаргалант сумын улсын бүртгэгч Т.Алтаншагай 117 мэдүүлэг хүлээн авснаас 116 бүртгэл, Хүрээмарал сумын улсын бүртгэгч Авирмэд 125 мэдүүлэг хүлээн авснаас 119 бүртгэл, харин Богд сумын улсын бүртгэгч Д.Мягмар 237 мэдүүлэг хүлээн авснаас 215 бүртгэл тус тус хийсэн байна.

2.3. “Улсын бүртгэлийн үйлчилгээнд дундын мэдээллийн сан ашиглах” зорилтын хүрээнд:

- Газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгэх дундын мэдээллийн санд 2018 оны 11 сараас өнөөдрийг хүртэлх хугацаанд 7671 хүсэлт ирснээс **“Дугаар олгосон-6303”**, **“татгалзсан-1367”**, **“хүсэлтэнд байгаа-1”** бүртгэл байна.

Газрын дундын мэдээллийн санд газрын алба, газрын даамлуудаас ирүүлсэн хүсэлтийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар хянан шалгаад улсын бүртгэлийн дугаар олгох, аль эсвэл улсын бүртгэлийн дугаар олгохоос татгалзсан шийдвэр гаргаж шийдвэрлэдэг байсан үед улсын бүртгэгч нар нийт 3988 дугаар олгож шийдвэрлэсэн байна. Харин 2021 оны 08 сараас эхлэн системээс автоматаар дугаар олгодог болсноос хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд **2315 дугаар олгогдсон** байна.

Харин газрын кадастрын мэргэжилтэн, газрын даамлуудаас эрхийн улсын бүртгэлийн дугаартай газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ хэвлээд буцааж Газрын дундын мэдээллийн сандаа оруулахгүй байгаа алдаа дутагдал байсаар байна. Тодруулан, **нэг жишээ татахад**, системээс автоматаар дугаар олгодог

болсноос хойш нийт олгогдсон **2315** дугаарт бүртгэлд **нэгж талбарын гэрээ, гэрчилгээг оруулаагүй** 2047, оруулсан нь 268 байна. Энд Системээс автоматаар дугаар олгохоос өмнө олгосон улсын бүртгэлийн дугаар бүхий нэгж талбарын гэрээ, гэрчилгээг системд оруулаагүй байгаа тоог оруулж тооцоогүй болохыг онцлоё.

- **“Нотариатчтай мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулах, дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл нийлүүлэх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд нотариат зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх”** зорилтын хүрээнд;

Баянхонгор аймагт нотариатын үйлчилгээ эрхлэдэг эрх бүхий 3 нотариатч нотариатчийн үйл ажиллагаа эрхлэж байгаа ба 2021 онд 2 нотариатч УБЕГ-тай мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ байгуулсан байгаа боловч өнөөдрийг хүртэлх хугацаанд дундын мэдээллийн санд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээлэл нийлүүлээгүй байна.

Харин гэрээ байгуулсан нотариатуудтай УБЕГ-аас “Нотариатчтай мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулах зорилтод ажлын бэлтгэлийг хангахад, нөгөө талаар мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах ажиллагааны хүрээнд нэг мөр ойлголттой байж иргэд чирэгдүүлэхгүй байхад чиглэгдсэн хамтарсан мэдээлэл солилцох зорилго бүхий сургалт, зөвлөгөөг 6 сарын 3-нд хийлээ. Уг сургалт, зөвлөгөөнд аймгийн нотариатуудаас гадна сумдын ЗДТГ-ын дарга нар буюу нотариатын үүрэг гүйцэтгэгч нар, сумын ЗДТГ-ын дотоод асуудал хариуцсан эрх зүйн мэргэжилтэн буюу нотариатын үүрэг гүйцэтгэгч нар оролцлоо.

Тус сургалт, зөвлөгөөнөөр “Нотариатын үйлдэл улсын бүртгэлд нөлөөлөх нь” сэдвийн хүрээнд Улсын бүртгэлийн багц хуульд орсон зарчмын томоохон өөрчлөлт, улсын бүртгэлийн зорилго, ач холбогдол, үр нөлөө, Хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой гэрээ, хэлцлийг гэрчлэх нотариатын үйлдэл хийхдээ анхаарах зүйл, нотариатын хууль зүйн шаардлага хангаагүй үйлдэл, гэрчилсэн гэрээ хэлцлийн үр дагавараас хамаарч улсын бүртгэл хүчингүй болох нөхцөл зэрэг асуудлыг хөндсөн хэлэлцүүлгийг өрнүүлж, харилцан санал солилцохын зэрэгцээ Улсын бүртгэлийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа улсын бүртгэлийн цахим үйлчилгээ болон иргэний тоон гарын үсгийн талаар цаг үеийн мэдээ, мэдээллийг хүргэж, нийгмийг манлайлан улсын бүртгэлийн цахим үйлчилгээний идэвхитэй хэрэглэгч болохыг уриаллаа.

Нотариат, Нотариатын үүрэг гүйцэтгэгчээс гадна Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотойгоор мэдээлэл нийлүүлдэг, улсын бүртгэлд бүртгэгдэх гэрээ хэлцэл гэрчилдэг зэрэг чиг үүргээрээ зайлшгүй холбогддог албан хаагч

мэргэжилтэн /нотариатын үүрэг гүйцэтгэгч, Хоршоо дэмжих сангийн мэргэжилтэн, газрын даамал, банкны эдийн засагч/ -ийг чадавхижуулах, мэргэжлийн арга зүйгээр хангах замаар төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий сургалтыг Хэлтсийн даргаар батлуулан зохион байгуулсан ба **нийт 14 удаагийн сургалт явагдаж, давхардсан тоогоор 840 ажилтан, албан хаагч** хамрагдсан.

Дүгнэхэд, хөдөө орон нутагт ажиллаж байгаа нотариатуудтай гэрээг шинэчлэн хийх, нотариатуудыг хуулиар хүлээсэн мэдээлэл нийлүүлэх чиг үүргээ хэрэгжүүлж хуулийг хэрэгжүүлэх, мөн хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар шуурхай арга хэмжээ авах хэрэгцээ шаардлага үүсч байна.

3.1. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд буюу 2021 оны 12 дугаар арын 05-ны өдрөөс 2022 оны 11 сарын 25-ны байдлаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт 8123 мэдүүлэг хүлээн авч, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн байна. Үүнээс Анхны бүртгэл 9081, эрх шилжсэн бүртгэл 1300, барьцааны эрхийн бүртгэл 4553, лавлагаа, хуулбар 83, бусад бүртгэл 2, эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт орсон бүртгэл 1043, хувийн хэрэг хаах бүртгэл 43 бүртгэл бүртгэгдсэн байна.

Эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ хаяж, үрэгдүүлсэн бүртгэл буюу гэрчилгээ хүчингүйд тооцуулж дахин гэрчилгээ олгох бүртгэлийг хийхдээ ЭХЭУБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5.3 дахь заалт, УБЕГ-ын даргын 2020 оны А/1172 дугаар тушаалын дагуу Хяналтын байцаагчийн 43 удаагийн дүгнэлт гаргуулж, бүртгэлийг хууль, журмын хүрээнд хийсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт үзүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт үйлчилгээний хураамж 47.456.806 төгрөгийг, орон нутгийн төсөвт тэмдэгтийн хураамж 4.735.424 төгрөгийг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны орлогын албан татвар 280.439.867 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.


Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн үйлчилгээний төрлөөр нь ангилвал;

1. Газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, эзэмших эрхийн бүртгэл:

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг анх удаа бүртгүүлж баталгаажуулах бүртгэл **нийт 548**, үүнээс шинээр баригдсан орон сууцны өмчлөх эрхийг баталгаажуулах бүртгэл 239, Төрөөс худалдаж авсан үл хөдлөх эд хөрөнгийн

өмчлөх эрхийг баталгаажуулах бүртгэл 6, Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг анх удаа бүртгүүлэх бүртгэл 291, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ, хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх бүртгэл 12 тус тус бүртгэгдсэн байна.

Харин газар өмчлөх, эзэмших эрхийг анх удаа баталгаажуулах бүртгэл 385, үүнээс төрөөс үнэгүй хувьчилсан газрын өмчлөх эрхийг баталгаажуулах бүртгэл 372, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салснаар шинэ бүртгэл үүсгэх бүртгэл 13 бүртгэгдсэн байна.



2. Газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн гэрээний эрхийн улсын бүртгэл:

а/. Үл хөдлөх эд хөрөнгө: Худалдах, худалдан авах гэрээ 3859, бэлэглэлийн гэрээ 20, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх хэлцэл 52, өмчлөгч өөрт ногдох хэсгээ бусад өмчлөгчид бэлэглэх гэрээ 48, өмчлөгч өөрт ногдох хэсгээ бусад өмчлөгчид худалдах гэрээ 3, өмчлөгч өөрт ногдох хэсгээс бэлэглэх гэрээ 35, хамтран өмчлөгч өөрчлөгдөх хэлцэл 1, шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 1 тус тус бүртгэгдсэн байна.

Мөн Барьцаалбартай барьцааны гэрээ 719, барьцаалбаргүй барьцааны гэрээ 520, барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах гэрээ 78, барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах гэрээ 20, барьцааны гэрээ дуусгавар болох бүртгэл 1057, барьцааны үүргийн зарим хэсэг дуусгавар болох бүртгэл 24 тус тус бүртгэгдсэн байна.

б/. Газар: Худалдах, худалдан авах гэрээ 489, бэлэглэлийн гэрээ 33, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 118, хамтран өмчлөгч өөрчлөгдөх хэлцэл 5, өмчлөгч өөрт ногдох хэсгээс бэлэглэх гэрээ 6, өмчлөгч өөрт ногдох хэсгээ бэлэглэх

гэрээ 89, өмчлөгч өөрт ногдох хэсгээ худалдах гэрээ 8, өмчлөгч өөрт ногдох хэсгээс худалдах гэрээ 1 тус тус бүртгэгдсэн байна.


Мөн барьцаалбаргүй барьцааны гэрээ 1084, барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах гэрээ 22, барьцааны гэрээ дуусгавар болох бүртгэл 1014, барьцааны үүргийн зарим хэсэг дуусгавар болох бүртгэл 14 тус тус бүртгэгдсэн байна.

3. Бусад бүртгэл:

а/. Үл хөдлөх эд хөрөнгө:

Эд хөрөнгийн үнэ, хэмжээ өөрчлөгдөх бүртгэл 140, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх бүртгэл 5, өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салснаар хэмжээ өөрчлөгдөх бүртгэл 30, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 115, эд хөрөнгийн үнэ, өмчлөгчийн овог, нэр, регистр өөрчлөгдөх бүртгэл 4, үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох бүртгэл 16 тус тус бүртгэгдсэн байна.

б/. Газар: Эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх бүртгэл 506, өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар хэмжээ өөрчлөгдөх бүртгэл 7, өмчлөгчийн овог нэр регистрийн дугаар өөрчлөлтийн бүртгэл 6, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 182, газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх бүртгэл 3, үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох бүртгэл 27, гэмтээсэн гэрчилгээ шинээр олгох 2 тус тус бүртгэгдсэн байна.



- Хаягжуулалтын хуулийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн хаяг шинэчилэгдсэнтэй холбоотойгоор хаяг өөрчлөлтийн бүртгэл нийт 978 бүртгэл бүртгэгдсэн байна.

- Мөн МИК активаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу эрх сэргээсэн тусгай тэмдэглэлийн бүртгэл 58, хууль хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дагуу эрх сэргээсэн 26, эрх түдгэлзүүлсэн бүртгэл 58 бүртгэгдсэн байна.

Тайлант хугацаанд сумдын улсын бүртгэгч нараас нийтдээ **454 мэдүүлэг** ирүүлэн шийдвэрлүүлсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөө сумдад газар дээр хүргэх ажлыг Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Баян-овоо сумдад 2022 оны 06 сарын 09-13-ны өдрүүдийн, Жинст, Богд, Баянлиг, Баянговь сумдад 2022 оны 11 сарын 13-15-ны хооронд зохион байгуулав. Орчим иргэнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн ба 152 иргэн өмчлөх эрхийн гэрчилгээгээ гардан авсан байна. Мөн E-Mongolia цахим үйлчилгээний нэгдсэн систем талаар 128 иргэнд мэдээлэл хүргэж, цахим үйлчилгээг өргөн ашиглаж сурах талаар зөвлөгөөг өгч иргэд цахимаар лавлагааны үйлчилгээ үзүүлсэн байна.

4. Лавлагаа, хуулбар:

Эд хөрөнгийн бүртгэлийн лавлагаа 46, архивын лавлагаа болох эд хөрөнгөтэй эсэх, эд хөрөнгийн түүхчилсэн лавлагаа 73 нийт 109 лавлагаа олгож, эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой нотлох баримтын хуулбар 63 мэдүүлгээр 172 хуудас нотлох баримтыг олгосон байна.

5. Гэрчилгээ олголт:

- Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбогдуулан газар өмчлөх эрхийн гэрчилгээ 1863, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ 1398, **нийт 3261** гэрчилгээ бичиж олгосон байна.

Тав. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын талаар:

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 2022 оны 11 сарын 25-ны байдлаар 19180 хувийн хэрэг хадгалагдаж байгаагаас газар өмчлөх эрхийн бүртгэлийн хувийн хэрэг 9143 /газар эзэмших, ашиглах эрхийн хувийн хэргийг хувийн хэргээс хасч 250 нэгжээр хадгаламжийн нэгж үүсгэн хадгалж болсонтой холбоотой./, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хувийн хэрэг 10037 байна.

Тайлант хугацаанд шинээр үүссэн 933 хувийн хэрэг хүлээн авч, 7190 хувийн хэрэгт баяжилт хийгдсэн байна.

Харин газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэлийн хувийн хэрэг үүсгэхгүйгээр хадгаламжийн нэгж бий болгох болсонтой холбоотойгоор газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэлийн дугаар олгосныг батлах маягыг цахимаас хэвлэн авч 250 хуудастай хадгаламжийн нэгж үүсгэн архивлаж байна.

- Хувийн хэрэг бүртгэл хаахтай холбоотой УБЕГ-ын даргын тушаалаар 43 хувийн хэрэг бүртгэлийг хаах бүртгэлийг бүртгэн баталгаажуулсан байна.

- Шинээр баригдсан орон сууцны жагсаалт, тухайн орон сууцны өмчлөх эрхийг нотолсон баримт бичгийг тасгийн дарга хянасны дараагаар хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагчаар давхар хянуулан үндсэн баримтын хуулбар хувийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт цаасан баримтын нэгж үүсгэн хадгалж байна.

Зургаа. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хяналтын талаар:

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг өдөр тутам цахимжуулах ажил хийгдэж байгаа ба цахимжуулалтыг үнэн зөв, чанартай гүйцэтгэж байх талаар улсын бүртгэгч нарын өдөр тутам бүртгэн цахимжуулсан бүртгэлийг давхар хянан ажиллаж байна.

Эд хөрөнгийн газрын даргаас ирүүлсэн чиглэлийн дагуу 50.000.000 төгрөгөөс дээш үнийн дүнтэй барьцааны гэрээний бүртгэлийг **“Эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэх эсэх тухай дүгнэлтийн хуудас”**-аар тасгийн дарга, түүний эзгүйд хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагчид танилцуулан холбогдох дүгнэлт, саналыг авч зохих бүртгэлийг хуулийн шаардлагад нийцүүлэн хөтлөж байна.

Тайлант хугацаанд **“Хэд хэдэн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан гэрээ, ипотек болон шаардах эрх шилжүүлэх гэрээг улсын бүртгэлд бүртгэх хяналтын хуудас”-аар** 50.000.000 саяаас дээш үнийн дүнтэй 395 үл хөдлөх эд хөрөнгө барьцаалагдсан Барьцааны гэрээний бүртгэл танилцуулагдаж, зохих шийдвэр, зөвлөмжийн дагуу бүртгэгдсэн байна. “Хяналтын хуудас”-аар танилцуулагдан бүртгэгдэж байгаа бүртгэлийг тасгийн дарга хяналтаа авч, давхар бүртгэдэг ба энэ нь бүртгэлийн дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа нэгэн хэлбэр юм.

ТАВ.БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ;

5.1.Бүртгэлийн хяналт хийсэн талаар:

5.1.1. 2022 оны 11 дүгээр сарын 29-ний байдлаар бүртгэлийн төрөл тус бүрд хяналт тавьсан байдал.

Иргэний бүртгэлийн чиглэлээр 1451, Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 1084, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 353, Архивын чиглэлээр 620, нийт **3508** бүртгэлд хяналт тавин ажиллалаа. **Хяналтын явцад** Иргэний бүртгэлийн 187, Эд хөрөнгийн чиглэлээр 110, Хуулийн этгээд 108, Улсын бүртгэлийн архивын /иргэний/ чиглэлээр 31, нийт **385** зөрчил илрүүлснийг тухай бүр залруулж ажиллав.

2022 оны Хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төлөвлөгөөт шалгалт-1, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт-3, Өргөдөл, санал, гомдлын мөрөөр хийсэн шалгалт-336, нийт хяналт шалгалт **340** байна. Төлөвлөгөөт шалгалтаар 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 20-ны өдрүүдэд Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо сумдад ажилласан бол 2022 оны 11 сарын 13-ны өдрөөс 15-ны өдрүүдэд Богд, Баянговь, Баянлиг сумдад ажиллаж хяналт шалгалт хийсэн байна. Тус хяналт шалгалтаар 341 бүртгэлд хяналт шалгалт хийснээс 5 бүртгэлд зөрчил илрүүлснийг газар дээр нь арилгаж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газраас хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй гэх 100 төрийн байгууллагын жагсаалт ирүүлснээс бүртгүүлэх хүсэлт гаргасан 39 байгууллагын бүртгэлийн нотлох баримтанд хяналт тавьж 12 байгууллагад зөвлөгөө өгсөн байна.

5.1.2. Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт. Зөрчлийн тухай хуульд заасны дагуу нийт **383** иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэв. Үүнээс 382 иргэн, 1 хуулийн этгээдэд шийтгэл ногдуулж, улсын төсөвт **8 140 000** төгрөгийн орлого төвлөрүүллээ. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байхад анхаарч ажиллаж байна. Мөн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хуульд заасны дагуу Прокурорын байнгын хяналтан дор хугацаанд нь хянуулан хамтран ажиллаж байна.

Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл ногдуулсан иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг бүртгэлийн төрлөөр нь ангилвал биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл анх удаа бүртгүүлэх хугацаа хэтрүүлсэн /16 нас/-119, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хуулийн хугацаанд бүртгүүлээгүй /25 нас/-125, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хуулийн хугацаанд бүртгүүлээгүй /45 нас/-115, төрсний бүртгэлийн хугацаа хэтрүүлсэн -16, нас барсны бүртгэлийн хугацаа хэтрүүлсэн -5, Гэрлэлт цуцлалтыг хуулийн хугацаанд бүртгүүлээгүй-2, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орсныг хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй -1 бүртгэлүүд байна.

Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 онд 16, 25, 45 насанд хүрч буй 10 дугаар багийн 124, 1 дүгээр багийн 117, нийт 241 иргэнтэй Багийн засаг дарга, нийгмийн ажилтантай хамтран утсаар

холбогдож хуулийн хугацаандаа бүртгэл хийлгэхийг зөвлөж, Зөрчлийн тухай хуулиар мэдээлэл хүргэж ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр ирүүлсэн “Иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийх” хяналт шалгалтын удирдамжийн дагуу аймгийн төвийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнсний дэлгүүр, зочид буудал, барьцаалан зээлдүүлэх газар, ТҮЦ, эмийн сангийн үйл ажиллагаанд Цагдаагийн газрын Нийгмийн хэв журмыг хамгаалах тасгийн эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлагч Ж.Цэвээндорж, цагдаагийн дэд ахлагч Д.Гончигдорж нартай хамтран 2022 оны 10 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд шалгалт хийж ажиллав. Шалгалтанд нийт 72 аж, ахуйн нэгж байгууллага, иргэн хамрагдсан бөгөөд үүнээс аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 112 хүнсний дэлгүүрээс 59, 12 зочид буудлаас 9, 11 барьцаалан зээлдүүлэх газраас 4, 19 эмийн сангаас 9 эмийн сангийн үйл ажиллагаанд шалгалт хийхэд үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалсан зөрчил илрээгүй болно.

Мөн томилолтоор сумдад ажиллахдаа сумын дэлгүүр, эмийн сан, шатахуун түгээх станц зэрэг газруудад улсын бүртгэлийн бичиг баримт барцаалсан, барьцаалуулсан зэрэг үйлдэл байгаа эсэхэд хяналт тавьж, холбогдох зөвлөгөө мэдээллийг өгч ажиллалаа.

5.1.3. Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийн талаар.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, алдаа зөрчил гаргахгүй, улсын бүртгэлийг хууль зүйн дагуу үнэн зөв бүртгэл хөтлөх зорилтыг тавин ажиллаж байна.

2022 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар Хяналтын улсын байцаагчийн нийт **257** дүгнэлт гаргаснаас иргэний бүртгэлийн чиглэлээр гарсан дүгнэлтүүдийг хүснэгтээр харуулвал. Үүнд:

№	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
1	Бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах тухай	153
2	Бүртгэл хүчингүй болгох тухай	40
3	Регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай	12

	Нийт	205
--	-------------	------------

Бүртгэлийн төрлөөр ангилвал.

№	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
1	Иргэний бүртгэл	205
2	Хуулийн этгээдийн бүртгэлийн талаар	4
3	Эд хөрөнгө	48
	Нийт	257

Хяналтын улсын байцаагчаас гарсан шийдвэрийг харуулбал:

№	Хяналтын улсын байцаагчийн	тоо
1	Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	257
2	Хяналтын улсын байцаагчийн шийтгэлийн хуудас	383
3	Хяналтын улсын байцаагийн мэдэгдэл	0
4	Хяналтын улсын байцаагчийн акт	0
5	Хяналтын улсын байцаагчийн албан шаардлага	0
	Нийт	640

Дөрөв. Бусад ажлын талаар

2022 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн нийт **122** өргөдөл хүлээн авснаас 86 өргөдлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр, 8 өргөдлийг улсын бүртгэгчид шилжүүлсэн, 4 өргөдлийг нотлох баримтын шаардлага хангаагүй, нотлох баримт нэмж бүрдүүлэх шаардлагатайн улмаас буцаасан /иргэнд/, 3 өргөдлийг албан тоотоор хариу өгч, 3 өргөдлийг амаар /утсаар хариу өгч/ хариу өгч шийдвэрлэсэн, 18 өргөдлийг шийдвэрлэхээр шалгаж байгаа.

Мөн хэлтсийн эрх бүхийн албан тушаалтны нийт **254** хүсэлтийг хүлээн авсан байна. Үүнээс эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 52 хүсэлт, Иргэний бүртгэлтэй холбоотой 195 хүсэлт, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой 4 хүсэлтийг тус тус хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарган шийдвэрлэсэн байна. Эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 1 хүсэлт, иргэний бүртгэлтэй холбоотой 2 хүсэлтийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Хяналт шалгалтын газрын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 7/9579 тоот дотоод албан бичиг, хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд бүртгэгдсэн Эд хөрөнгийн эрхийн улсын 718 бүртгэлд /ХУБ Л.Мэндбаяр/, Иргэний улсын бүртгэлийн 566 бүртгэлд /ХУБ С.Баярмаа/, Хуулийн

этгээдийн 98 бүртгэл, иргэний бүртгэлийн 389 бүртгэлд /Хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал/ тус тус хяналт шалгалт хийв.

Тус онд 3 гомдол хүлээн авснаас 2 гомдлыг газэр дээр нь хүлээн авч шийдвэрлэж, Баян-Овоо сумын Засаг дарга нь Монгол улсын Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвд хандаж “Баянхонгор аймгийн төвийн сургуульд хүүхдээ сургахын тулд маш олон иргэд хууль бусаар хаягийн шилжилт хийлгэж байна. Тус сумд ерөнхий боловсролын сургууль байсаар байтал аймгийн төвийн сургуульд хууль бусаар хүүхэд элсүүлж байна энэ тухай холбогдох газарт уламжлан шалгуулж өгнө үү” гэх гомдлын дагуу 2022.01.02-ны өдрөөс 2022.09.15-ны өдрийг дуустал хугацаанд Баян-Овоо сумаас аймаг, сум, баг хороонд шилжсэн, тус суманд шилжин ирсэн шилжилт хөдөлгөөний нийт 73 бүртгэлийг шалгахад Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 332 тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэл журам”-ыг зөрчиж буюу хууль бусаар бүртгэл хийсэн зөрчил илрээгүй тул ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст энэ тухай 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 1/805 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.

Тус хяналт шалгалтаар бүртгэлийн холбоотой алдаа, зөрчил илрээгүй боловч мэдээллийн санд цахимжсан нотлох баримт харагдахгүй /программын алдааны улмаас/, нээгдэхгүй байгаа эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 72, иргэний бүртгэлтэй холбоотой 3, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой 4 бүртгэлд тус тус зөрчил илрүүлснийг холбогдох албан тушаалтнуудад хандаж шаардлагатай засвар өөрчлөлтийг хийж, зөрчлийг арилгуулав. Дээрх хяналт шалгалт хийгдсэнтэй холбоотой илтгэх хуудсыг Хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал Хяналт шалгалтын газарт 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр j.chiimaa@burtgel.gov.mn хаягт хүргүүлсэн болно.

2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар бүртгэлийн хяналтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын мэдээг Хяналт шалгалтын газарт 11 удаа хугацаандаа хүргүүлсэн /ch.erdenechimeg@burtgel.gov.mn, sh.urtnasan@burtgel.gov.mn/, Аймгийн Прокурорын газарт зөрчлийн хэрэг бүртгэлийн чиглэлээр хүлээн авсан өргөдөл, гомдлын мэдээг өдөр бүр bayankhongor@prokuror.mn хаягаар илгээж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн зөрчлийн материалыг ажлын 5 өдөрт багтаан тухай бүр хүргүүлэн

хянуулан ажиллаж байна. Мөн хэлтсийн нягтлан бодогчид маягт үнэт цаасны мэдээ, 11 удаа хугацаандаа өгч ажиллалаа.

ЗУРГАА. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛАХ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙН САЙЖРУУЛАЛТ;

6.1. Программ хангамжийн талаар:

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох” төслийн хүрээнд бүртгэлийн байгууллагын сум, хорооны нэгжийг онлайн сүлжээнд холбох ажил бүрэн дуусч иргэд үйлчлүүлэгчид оршин байгаа газраасаа бүртгэлийн үйлчилгээ авах таатай нөхцөл бүрдэж бүртгэлийн үйлчилгээ орон зай, цаг хугацаанаас үл хамааран түргэн шуурхай хүртээмжтэй хүргэж ажлаад 2 жилийн нүүр үзэх гэж байна.

УБЕГ-аас бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах системийн өөрчлөлт, шинэчлэлтүүдийг үе шаттайгаар хийсээр байна. Энэ өөрчлөлтөд нийцүүлэн албан хаагчдыг чадавхжуулах, дадлагажуулах сургалтыг танхимаар болон онлайнаар зохион байгуулж хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдаж байна.

Бүх сумдын иргэний улсын бүртгэлийн онлайн системийн клиент программууд шинэчлэгдэж тухай бүрт нь бүртгэгч нэгт бүрт заавар зөвлөгөө өгч ажиллагаанд оруулж хэвийн ажиллаж байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумдад үзүүлж эхлэсэнтэй холбоотойгоор 3 сумын улсын бүртгэгчдийн бүртгэл хийхэд хэрэгцээт программуудыг суулган бүртгэлийн үйлчилгээ хэвийн явагдаж байна.

Мөн 2022 оны 05 сарын 02-оос Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гарын үсгийг хэрхэн яаж олгох талаар дадлагажуулах сургалтыг 3 удаа хийсэн, Гадаад паспортыг УБЕГ-т хэвлэж эхлэсэнтэй холбоотойгоор холбогдох сургалтуудад хамрагдаж дадлага ажлыг хийсэн зэргийг дурдъя.

6.2 Тоног төхөөрөмжийн талаар:

Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 онд тус хэлтэст хурууны хээ уншигч 20, иргэний цахим үнэмлэх уншигч 20 ирүүлснийг бүртгэгч нарт олгож ашиглаж байгаа ба Тоон гарын үсгийг олгоход хөдөлгөөнт сүлжээ шаардлагатай байсан тул УБЕГ-т санал хүргүүлснээр уг төхөөрөмжийг шийдвэрлүүлж ашиглаж эхлээд байна.

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан Баянхонгор сумын иргэдийн хаягийн шинэчлэлийн ажлыг хийх зардлаас уг ажиллагаанд ашиглахад

зориулж Dell-3080 үзүүлэлт бүхий иж бүрэн 2 ширхэг компьютерийг гэрээт ажилтнуудад хүлээлгэн өгч ажиллуулсан ба үргэлжлүүлэн хэлтсийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж байна.

Баацагаан сумын иргэний улсын бүртгэгчийн сүлжээний төхөөрөмж UTP кабел тасарч 40 м сүлжээний утсыг шинэчлэн ажиллагааг хэвийн болгосон. Мөн нэг цонхны үйлчилгээний сүлжээний медиа конвертор шатсан тул тус медиа конверторыг сольж хэвийн ажиллагаанд орууллаа.

Улсын бүртгэлийн Ерөнхий газраас хяналтын улсын байцаагчид олгосон 3 үйлдэлт 1 ширхэг принтер, гадаад паспортын зураг авахад ашиглах 2 ш зургийн аппарат зэргийг хүлээн авч үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

ДОЛОО. САНХҮҮ, ТӨСВИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2022 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар улсын төсвөөс 620,048,9 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч цалин хөлсний зардалд 405,623,6, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 57,146,4, гэрэл цахилгааны зардалд 2,043,0, түлш халаалтын зардалд 39,662,7, цэвэр бохир усны зардалд 1,193,3, бичиг хэргийн зардалд 8,400,0, тээвэр шатахууны зардалд 3,364,9, шуудан холбооны зардалд 1643,8, хог хаягдал зайлуулах зардалд 296,8, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 2,470,0, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 733,0, урсгал засварын зардалд 2248,8, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 1736,2, иргэдийн хаягийн шинэчлэл мэдээллийн санг шинэчлэх ажлын хүрээнд бараа үйлчилгээний бусад зардалд 13644,8 мянган төгрөгийг захирамжийн дагуу зарцуулж, улсын төсвийн орлогын дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 183,929,2 мянган төгрөг, орон нутгийн төвлөрүүлэх орлого 8,195,5 төгрөг төвлөрүүлэн ажиллалаа.

УБЕГ-ын Санхүү, аж ахуй хэлтсээс 11411,7 мянган төгрөгийн үнэт цаас, дэвтэр маягтыг хүлээн авч, 7928,8 мянган төгрөгийн үнэт цаас дэвтэр маягтыг зарцуулж хөдлөл өөрчлөлтийг бүртгэн сар бүр үнэт цаасны тайлан няравын тайланг гаргуулан авч, хүргүүлсэн.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж сар бүрийн тайлан, мэдээг УБЕГ-ын Санхүүгийн хэлтэст 11 удаа, Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст сар бүр, Татварын хэлтэст улирал бүр тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж баталгаажуулан харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж ажиллаж байна.

Байгууллагын 2023 оны төсөв, 2024-2025 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд нь УБЕГ-т хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn, сайтад сар бүр тогтмол байршуулан 133 удаагийн мэдээлэл шинэчилж, www.bayankhongor@burtgel.mn сайтад тогтмол байршуулан 11 удаагийн мэдээлэл шинэчилж ажилласан.

Сангийн яамны Цалингийн нэгдсэн системд албан хаагчдын мэдээллийг бүрэн оруулж цалинг олгож хэвшсэн. Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн програмд холбогдох мэдээллийг бүрэн оруулан шинэчилж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2021 оны Санхүүгийн тайлан, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Төрийн Аудитын байгууллагаар шалгагдаж ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажиллаж “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан болно.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2021 оны байгууллагын “Өмч эзэмшлийн гэрээ”-г дүгнэн 94 хувийн биелэлттэй ажилласан болно.

Батлагдсан төсөв хүрэлцэхгүйгээс шалтгаалж гэрэл цахилгааны зардалд 341,1, цэвэр бохир усны зардалд 828,4, хог хаягдлын зардалд 253,2, тээвэр шатахууны зардалд 922,9, нийт 2345,6 мянган төгрөгний өртэй байна.

НАЙМ. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ АЖИЛЛАГАА

8.1. Байгууллагын архив, бичиг хэргийн эргэлтийн бүртгэл, тайлан

Хэлтсийн хэмжээнд 2022 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар ирсэн албан бичиг **793**, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаал, чиглэл, зөвлөмж, дотоод албан бичиг нийт **65** тус тус бүртгэж, хэлтсээс **983** албан бичиг явуулсан байна. Явсан албан бичгийг тухай бүр **Able**, **Erp.e-mongolia.mn** программ дээр бүртгэн тухайн байгууллагаруу нь илгээдэг. Албан байгууллагаас ирсэн хариутай бичгийн тоо **525**, хугацаа хэтрүүлэн өгсөн албан бичиг байхгүй болно.

Өргөдөл, гомдлыг бүртгэлийн дэвтэр дээр болон **Able** программ дээр бүртгэн хяналтын карттай гарган цохогдсон албан хаагчдад шилжүүлдэг.

Удирдлагаас гарах шийдвэрийн болоод зохион байгуулалтын баримт бичиг буюу Хэлтсийн даргын **A** тушаал **15**, **B** тушаал **5** тус тус гарч, хамт олын хурлын тэмдэглэл **5** удаа гарсан байна.

8.2 Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу байгууллагад ирсэн өргөдлийг бүртгэлжүүлэн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн нийт **155 өргөдөл ирсэн**. Үүнээс бүрэн шийдвэрлэсэн **137**, шийдвэрлэх шатандаа **18** өргөдөл байна.

- Лавлагаа мэдээлэл болон архивын үйл ажиллагаатай холбоотой -1 (0,7%)
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой -16 (10,3%)
- Бүртгэлийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой -122 (78,7%)
- Албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцтэй холбоотой асуудал -15 (9,6%)
- Гомдол -1 (0.7%)

Мөн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой -46 өргөдөл шийдвэрлэж **нийт 201** өргөдөл, гомдол шийдвэрлэсэн байна. Үүнд:

8.3 Үйл ажиллагааг сурталчилсан байдал

УБЕГ-аас нэгдсэн байдлаар үүсгэн хөтлөж буй хэлтсийн вэйб хуудсанд хэлтсээс хийж хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, зохион байгуулсан сургалт, цаашид хийж хэрэгжүүлэх ажлууд, бүртгэлийн тоон мэдээ, нээлттэй ажлын байрны зар болон цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр нь байршуулж иргэд олон нийтэд түгээн дэлгэрүүлж ажиллаж байна. Тус /Bayankhongor.burtgel.gov.mn/ хаягт бүтэн жилийн байдлаар **73** үйл ажиллагааг сурталчлан байршуулсан байна. Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс гэсэн фэйсбүүк пэйж хуудсанд **288** удаагийн мэдээ мэдээллийг тавьж байршуулан иргэд олон нийтэд сурталчилж хамгийн олон хандалт авсан мэдээ мэдээлэл нь сарын шилдэг бүртгэгч шалгаруулан байршуулсан мэдээлэл, хэлтсээс олон нийтийн ажилд оролцсон тухай мэдээ мэдээллүүд байна.

Хэлтсийн албан хаагчдад УБЕГ болон хэлтсээс зохион байгуулсан ажил үйлчилгээ, орон нутгийн төр захиргааны байгууллагын бодлого шийдвэрийг сурталчлахад идэвхтэй оролцон холбогдох цахим хаягуудад хандалт хийж уншиж танилцаж, шэйр хийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах үүргээ гүйцэтгэж идэвхтэй ажиллах үүргийг өгч гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж хэвшсэн.

Аймгийн ЗДТГ-аас орон нутгийн TV-тэй Хууль зүйн яамны харъяа байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор байгуулсан гэрээний дагуу

Номгон TV –д хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 2 мэдээ мэдээллийг өгч олон нийтэд түгээн ажиллаж байна.


Байгууллагын үйл ажиллагааг сурталчилж буй бас нэг хэлбэр бол “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулах ажил бөгөөд төлөвлөгөөнд туссан дагуу хангайн 5 сумдад, Аймгийн Баганат талбайд 1, говийн 3 суманд тус тус 1 удаа зохион байгуулсан ажлууд бөгөөд энэ талаарх зар мэдээг мөн байгууллагын цахим хаягуудад оруулж иргэдийн идэвхи оролцоог ханган ажиллалаа.

Хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо сумдад “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2022 оны 05 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд, Богд, Баянлиг, Баянговь сумдад 11 дүгээр сарын 12-16-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж бүртгэлийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил үйлчилгээг сурталчилж, бүртгэлийн үйлчилгээг газар дээр түргэн шуурхай үзүүлэн, Бүртгэлийн байгууллагын цахимжилт, тоон гарын үсгийн талаар мэдээлэл өгч ажиллалаа.

Нээлттэй хаалганы өдөрлөгөөр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ **143**, зөвлөгөө мэдээллийг **168**, гарын авлага брошур **348** ширхэгийг тарааж, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр үндэсний гадаад паспортын бүртгэл **80**, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр **71**, **476** иргэний тоон гарын үсгийн бүртгэлийг тус тус хийсэн байна.

Мөн 6 дугаар сарын 28-ны өдөр мэдээлэл бэлтгэж сурталчлах ажлыг хэлтсийн хяналтын улсын байцаагчид, ахлах бүртгэгч нарт өгсөн дагуу Эд

хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга П.Бүжинлхам “Эрх зүйн боловсролыг иргэн бүрт” нэвтрүүлэгт оролцож бүртгэлийн үйлчилгээний талаар мэдээллийг нэгтгэж нийт 35 минутын нэвтрүүлэгт оролцов. Тус телевиз өөрийн цахим хуудаст 7 дугаар сарын 7-ны өдөр байршуулсныг хэлтсийн цахим хуудсуудаар сурталчилсан.



-Хэлтсийн хяналтын улсын байцаагч нараас аймагт 14 хоногт зохион байгуулагддаг Удирдлагын шуурхай мэдээллийн цагаар Хуулийн этгээдийн

бүртгэл, түүнд анхаарах асуудал ба Зөрчлийн тухай хуулийн холбогдох хэсгээр тус тус мэдээлэл хийсэн нь Зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг ажил боллоо.

ЕС. БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, ХӨГЖИЛ, ЁС ЗҮЙ

9.1. Албан хаагчдын сургалт, хөгжил

Байгууллагын нийт албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хэлтэс нь сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хагас бүтэн жилээр батлан хэрэгжүүлж хэвшсэн бөгөөд 2022 онд сургалт мэдээллийн ажлыг дараах байдлаар зохион байгууллаа.

- Аймгийн Насан туршийн боловсролын төвөөс оны эхэнд санал авсан дагуу хэлтсээс нийт 13 удаагийн сургалт авахаар захиалж 2022 оны танхимын анхны сургалтаа "Харилцаа ба хандлага" сэдвээр эхлүүлж 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хэлтсийн албан хаагчид танхимаар сумдын улсын бүртгэгчид онлайнаар, 2 дахь удаагийн сургалтыг мөн аймгийн Насан туршийн боловсролын төвөөс багш Б.Сэлэнгэ "Стресс гэж юу вэ" сэдвээр 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр, Насан туршийн боловсролын төвөөс "Экологийн ул мөр", мөн "Харилцан хүндэтгэе" аянд нэгдэж Жендэрийн хэвшмэл ойлголтоос татгалзах зорилтын хүрээнд "Жендэр ба хөгжил хандлага" сэдвүүдээр 3 дахь удаагийн сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр авч сургагч багш П.Даарийсүрэн, В.Наранчимэг нар оролцсон.

2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Аймгийн Насан туршийн боловсролын төвийн сургагч багш Г.Батжаргал "Минималист хэв маяг" сэдвээр, 4 дүгээр сарын 6-ны өдөр НТБТ-ийн багш Б.Сэлэнгэ "Эрүүл амьдралын хэв маяг", "Гэр бүлийн харилцаа" сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулж албан хаагчид идэвхтэй оролцлоо.

Аймгийн Насан туршийн боловсролын төвийн сургагч багш Туул "Цагийн менежмент" сэдвээр 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр сургалт хийж хэлтсийн албан хаагчид хамрагдаж сумдын албан хаагчид онлайнаар хамрагдсан болно.

УБЕГ-т 2022 оны 04 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Удирдах ажилтны нэгдсэн сургалт семинарийн дараагаар хэлтсийн нийт албан хаагчдын нэгдсэн сургалт зөвлөлгөөнийг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж явуулав.

Тус хөтөлбөрийн дагуу Аймгийн Насан туршийн боловсролын төвийн сургагч багш Мөнхнасан "Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо" сэдвээр 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр сургалт хийж хэлтсийн 38 албан хаагч танхимаар хамрагдлаа.

УБЕГ болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтууд:

Хэлтсийн дарга 01 дүгээр сарын 20-ны өдөр ISO 9001 стандартын танилцуулах сургалт, гүйцэтгэлийн үнэлгээний менежмент, Төрийн ёслолын тухай сэдэвт онлайн сургалт, Авлигатай тэмцэх газраас нийтийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан сургалтанд 2022.02.15 өдрийн 09.00 цагаас шинээр томилогдсон 3 албан хаагчдыг, Архив бичиг хэргийн эрхлэгч, ажилтнуудад зориулсан онлайн бичиг хэргийн эрхлэгч, Авлигын эсрэг АТГ-аас зохион байгуулсан давтан сургалтад, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай гэх мэт нийт 31 удаагийн онлайн сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулсан.

Хэлтсийн албан хаагчдад мэдлэг мэдээлэл өгч, чадавхжуулсан бас нэг сургалт бол Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж хэвшсэн 7:4:10 сургалт сургалт бөгөөд нийт 23 удаагийн сургалтанд хэлтсийн хамт олон хамрагдлаа.

Нийт албан хаагчдын оролцоог хэлтсийн дарга биечлэн бүртгэж идэвх оролцоог ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд мэдлэг чадвар хэсэгт харгалзан үздэг болно.

Үүнд сэдвүүдээс дурдвал: "Харилцан адилгүй үеийнхнийг үр дүнтэй манлайлах нь", "Хүлээлтэд нийцсэн гүйцэтгэлийг тодорхойлж өгөх нь", "Алдаа дутагдлыг шийдвэрлэх нь", "Гүйцэтгэлийг сайжруулах көччинг хийх нь", Чанарын менежментийн тогтолцоо ISO-9001", "Эх орон энхийг сахиулагч", "XXI зууны төрийн байгууллагын бүтээлч мэргэжилтэн, дэмжигч удирдагч", "Төрийн албан хаагчдын



НЭГ. ЗОРИЛГО

1.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Хэлтсийн албан хаагчдад Цахим хөгжлийн багц хуульд болон түүнтэй холбоотой бусад хууль тогтоомжид орсон өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл өгөх, байгууллагын дотоод үйл ажиллагааг шуурхай нэгдсэн удирдлагаар хангах, үйлчилгээний стандартыг мөрдүүлэх, өс зүйн болон бүртгэлийн алдаа зөрчилгүй ажиллахад ажилтнуудад үүрэг чиглэл, зөвлөмж өгөхөд оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

2.1 Сургалт зөвлөгөөнийг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр танхимаар зохион байгуулна. Хэлтсийн бүх албан хаагчид оролцоно.

ГУРАВ. ХӨТӨЛБӨР

Цаг	Үйл ажиллагаа
08.00-08.30	Гэмт хэргийг зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх нь У.Золзаяа
08.30-09.00	Хүний нөөцийн хөгжлийн бодлого, санхүүгийн төлөвлөлт Цагдаагийн газрын мэдээлэл
09.00-09.30	Цахим бүртгэлийн багц хууль, улсын бүртгэлийн ерөнхий хуульд орсон нэмэлт өөрчлөлт Хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал
09.30-10.00	Тусон гарын үсгийн программ ИТ ажилтан Р.Доржнямбуу
10.00-10.20	Цайны завсарлага
10.20-10.50	Хяналт шалгалтын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, цаашид анхаарах асуудал Хяналтын улсын байцаагч
10.50-11.40	УБЕГ-аас ирүүлсэн зөвлөмж чиглэлийн танилцуулга, хэрэгжүүлэхэд анхаарах асуудал ИУБТ-ын дарга бөгөөд ахлах бүртгэгч У.Золзаяа
11.40-12.15	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт Иргэний улсын бүртгэгч Э.Адьяабаяр
12.15-13.00	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга ХУБ Л.Мэндбаяр
13.00-14.00	Удрийн хөдөл Хэлтсийн амралтын өрөөнд /
14.00-15.00	Эд хөрөнгийн зөвхөн улсын бүртгэлийн чиглэлээр цаашид хийж хэрэгжүүлэх ажлын танилцуулга анхаарах асуудал ЭХЭУБТ-ын дарга бөгөөд ахлах бүртгэгч П.Бүжинлхам
15.00-16.00	Гэр бүлийн үнэ цэнэ Насан туршийн боловсролын төвийн сургагч багш
16.00-16.20	Асуулт хариулт
16.20-18.00	"Төрийн албаны нэр хүндийг эрхжилэн дээдлэх нь" хэлэлцүүлэг зохион байгуулах тусгай хөтөлбөрөөр/ Удирдан зохион байгуулагч: Баян-Өндөр сумын иргэний улсын бүртгэгч Д.Тэнсэг

—oOo—

үнэт зүйл, ёс зүй, ёс суртахууны төлөвшил”, ХЭҮК-ийн гишүүн Хууль зүйн ухааны доктор Д.Сүнжид “ТАХ-ын хөдөлмөрлөх эрх ба ялгаварлан гадуурхалтаас ангид байх”, “Монгол Улсын ардчилал, зах зээлийн шилжилтийн эхэн үеийн төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлт”, “ТАХ-ийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих”, “ТАХ-н ёс зүй”, Монгол бичиг үндэсний хөтөлбөр III -ийн хэрэгжилтийн явц, “Стресс менежмент” гэх сургалтуудад албан хаагчдыг бүрэн хамруулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа.

Хэлтсээс 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс Глобал Удирдагч Их сургуулийн Ахисан түвшний сургуулийн Эрх зүйн магистрын хөтөлбөрт хамрагдаж ажилтнуудынхаа мэдлэг чадвар, зэргийг ахиулах зорилгоор гэрээ байгуулж эрх зүйн магистрын ангид хэлтсийн 9 албан хаагчийг 1,5 жилээр элсэн суралцуулснаас нийт 6 албан хаагч амжилттай төгсөж 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Ромбо дипломоо гардаж авлаа. Бакалаврын хөтөлбөрт 7 албан хаагч хамрагдаж байна.

Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтын дагуу төрийн албан хаагчийн дунд хугацааны давтан сургалтанд суралцах хүсэлтэй албан хаагчдын саналыг авч хүргүүлснээр иргэний улсын бүртгэгч Э.Адъяабаяр сонгогдож Удирдлагын академийн төрийн албан хаагчийн дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдаж амжилттай дүүргэсэн гэх мэтчилэн УБЕГ болон бусад байгууллагаас орон нутагт зохион байгуулагдаж буй төрийн албан хаагчид хамаарах бүхий л сургалтанд хэлтсийн дарга болон холбогдох албан хаагчид бүрэн хамрагдаж мэдлэг мэдээллээ хамт олондоо түгээн дэлгэрүүлж ажил амьдралдаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

УБЕГ-ын албан хаагчид КОЙКА-ийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хүрээнд БНСУ-д албан хаагчдыг ээлж дараатай сургалтад хамруулж байгаа ба энэ оны эхний баг бүрэлдэхүүнд тус хэлтсийн мэдээллийн технологийн ажилтан Р.Доржнямбуу хамрагдав.

9.2. Албан хаагчийн ёс зүйн асуудал

Улсын бүртгэлийн байгууллага нь төрийн үйлчилгээний 70 гаруй хувийг үзүүлдэг, мөн өдөр тутамдаа байнгын ачаалалтай ажилдаг зэрэг ажлын онцлогоос шалтгаалан харилцааны ур чадварыг цаг ямагт шаардаж байдаг ба хамгийн гол нь харилцаа хандлага л чухал түүнд анхаарч түүнийг эрхэмлэн ажиллахыг зөвлөн ажиллаж байна.

Иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг тандах, албан хаагчдын харилцаа хандлагыг өөрчлөх, байгууллагын үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, үйлчилгээний стандартыг мөрдүүлэх зорилгоор

үйлчилгээний зааланд санал хүсэлтийн дэвтэр, өргөдөл гомдол хүлээн авах 70442177 утсыг тогтмол ажиллуулж байна.

Авлигын эрсдэлийн судалгаа хийх зорилгоор 4 асуумж бүхий судалгааг хэлтсийн цахим хаягт байршуулан дүгнэхэд 54 хүн асуулгад хамрагдснаас 48 хүн ямар нэгэн шан харамж өгч байгаагүй гэж хариулсан бол заримдаа гэж 6 хүн хариулсан байгаад хэлтсийн зүгээс дүгнэлт хийж албан хаагчдыг авлигад автахгүй байхад анхаарах, энэ төрлийн сургалтад хамруулах шаардлагатай гэж дүгнэсэн болно.

Хэлтсийн үйлчилгээний зааланд байрлуулсан санал гомдлын дэвтэрт 88 иргэн санал сэтгэгдлээ бичснээс талархал 67 , санал 19, гомдол 2 байна.

2022 онд ёс зүйн зөрчлийн гаргасан талаар 1 ажилтанд холбогдуулж нэг иргэнээс гомдол ирүүлснийг УБЕГ-т хүргүүлж Ёс зүйн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 29-ний 02 дугаар тогтоолоор ёс зүйн зөрчил тооцож сануулах ёс зүйн хариулцага хүлээлгэсэн. Өнөөдрийн байдлаар дахин ёс зүйн зөрчил гаргасан талаар ямар нэгэн гомдол мэдээлэл ирээгүй байна.

АРАВ. ОРОН НУТАГ ДАХЬ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Аливаа байгууллага орон нутгийн удирдах байгууллага, түүний хамт олонтой нягт хамтран ажиллах нь төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгууллага чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэх бас нэгэн тулгуур билээ. 2022 байдлаар хэлтсээс орон нутагтай дараах байлаар хамтарч ажиллалаа.

Тус аймгийн салбар зөвлөлөөс санал хүргүүлснээр ТЕГ-аас Терроризмтой тэмцэх салбар зөвлөл болон хамтын ажиллагааны зөвлөлөөс 1 дүгээр сарын 10 - ны өдөр Баянхонгор аймгийн төрийн албан хаагчдын дунд “Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх”, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх” гэсэн 2 чиглэлээр сургалт, хэлэлцүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Уг сургалтанд Хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал, нягтлан бодогч Г.Бат-Очир, бичиг хэргийн эрхлэгч Ж.Болортуяа, Хяналтын улсын байцаагч С.Баярмаа нарын 4 албан хаагч хамрагдав. Сургалтыг Терроризмтой тэмцэх зөвлөлийн нарийн бичгийн дарга хурандаа Ж.Төгс-Очир ахлан бүрэлдэхүүнд тус зөвлөлийн ажилтан, ахмад Д.Дүгэрсүрэн, М.Бат-Соёмбо, ОБЕГ-ын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б.Мягмарсүрэн, МХЕГ-ын Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, хамтын ажиллагааны зөвлөлөөс Монголбанкны Хуулийн зөвлөх Б.Гантуяа болон цахимаар Санхүүгийн зохицуулах хороо, ЦЕГ-аас холбогдох албаныхан оролцон явууллаа.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газраас санал тавьсан дагуу Баянхонгор сумын багуудын иргэдийн нийтийн хурлуудад хуваарийн дагуу баг бүрт 1 албан хаагч оролцож холбогдох мэдээллийг өгч хамтран ажиллав.



Мөн сумын Засаг даргын захирамжийн дагуу сар бүрийн 12-ны өдөр хуваарьт газартаа бүх нийтийн цэвэрлэгээ хийхээр тогтоосон дагуу хэлтсийн албан хаагчид аймгаас баруун тийш зорчих хот хоорондын замын хоёр талаарх хог хаягдлыг 8 удаа цэвэрлэж дахивар хог хаягдлыг тушаах цэгт нь хүргэж өгч ажиллаж байна.



-Архив, албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Төрийн архиваас аймгийн ЗДТГ-ын нийт албан хаагчдад 03 дугаар сарын 09-нд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтсүүдэд 03-р сарын 10-нд, аймгийн төвийн төрийн байгууллагын дарга, архив, бичиг хэргийн ажилтнуудад 03-р сарын 11-ний өдрүүдэд тус тус сургалт зохион байгуулсан ба хэлтсээс холбогдох албан хаагчид бүрэн хамрагдлаа. Дээрх сургалтаар шинэчлэгдсэн Архив албан, хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Баримт бичгийн стандарт, орон нутгийн бодлого арга хэмжээний талаар Төрийн архивын тасгийн дарга В.Эрдэнэчимэг танилцуулж, шинээр орсон удирдлагын системийн ашиглалт, хяналт, идэвхжүүлэлтийг анхаарч, тоон гарын үсэгт шилжих талаар мэдээлэл зөвлөмж өглөө.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих аянд нэгдэж Баянхонгор аймагт зохион байгуулагдсан "ЭРҮҮЛ ИРГЭН - ЭРТЭЧ БАЯНХОНГОРЧУУД" аянд хуваарийн дагуу 2022.03.23-ны өдөр УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН хамт олон Биеийн тамир спортын газрын зааланд 06.30-07.30 хооронд дасгал хөдөлгөөн хийлээ.



- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлсэн бөгөөд Баянхонгор аймаг 2022.05.13-ны өдөр “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнд нэгдэж албан ёсоор нээлтээ эхлүүлсэн. Мод тарих үндэсний өдрийг албан ёсоор эхлүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний нээлтэд тус хэлтсийн хамт олон оролцож хуваарьт газартаа ээлжит мод тарих ажлаа эхлүүлж байгууллагын хариуцсан ойн зурвас бүхий газарт 54 ш мод, Мод тарих үндэсний өдрөөр буюу 10 дугаар сарын 8-ны өдөр тус хэлтсийн хамт олон байгууллагын хуваарьт газар болох Шинэ суурьшилын бүсэд тарьж ургуулсан модны арчилгаа, орчны хог хаягдлыг цэвэрлэх ажлуудыг хийлээ. Мөн цаашид ургах чадваргүй болсон модыг авч 10 ш модыг нөхөн тарьж цэнэг усалгааг бүрэн хийж дуусгалаа. “Хамтдаа байгаль эх дэлхийгээ хайрлацгаая” уриан дор энэ онд нийт тарьсан модоо арчлан,



услах ажлыг 8 удаа хийж гүйцэтгэлээ.



“ДИЖИТАЛ БАЯНХОНГОР” НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГТ ХАМТРАН АЖИЛЛАВ.

Төрийн цахим үйлчилгээг иргэд, олон нийтэд танилцуулах, “E-Mongolia.mn” болон бусад цахим системээр дамжуулан өөрт хэрэгтэй үйлчилгээг хэрхэн, яаж авах талаар иргэдэд сурталчлах, тайлбарлан таниулах зорилгоор “Цахим жишиг аймаг” хөтөлбөрийн хүрээнд Улсын Их хурлын Тамгын газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, E-Mongolia академи, Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг Даргын Тамгын газар, бусад хэлтэс агентлагуудтай хамтран 2022 оны 05 дугаар сарын 22-ны Ням гарагт “Дижитал Баянхонгор” нээлттэй өдөрлөгийг төв талбайд амжилттай зохион байгууллаа.

Тус өдөрлөгт Улсын Их хурлын дарга Г.Занданшатар, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Бодлого төлөвлөлтийн газрын дарга З.Гантогоо, “И монгол” Академийн захирал Л.Энхбат, “Мобиком” корпорацийн гүйцэтгэх захирал Кожи Курушима, “Юнител” группын гүйцэтгэх захирал Д.Энхбат нар оролцлоо.

“Нээлттэй хаалганы өдөрлөг” өөр тус хэлтсээс 3 бүртгэлийн чиглэлээр 28 бүртгэл хийж, 86 иргэнд зөвлөгөө мэдээллийг хүргэснээс тоон гарын үсэг 318 иргэнд олгосон байна.



-Баянхонгор аймгийн Бөмбөгөр суманд зохион байгуулагдсан "Бөмбөгөр - 100" арга хэмжээний хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 11-ний амралтын өдөр тус хэлтсээс "Нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгууллаа. "Нээлттэй хаалганы өдөрлөг"-өөр Иргэний улсын бүртгэлийн 6, лавлагаа олголт 12, тоон гарын үсгийн бүртгэл хийж 44 иргэнд олгосон бол Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 16 бүртгэл хийж гэрчилгээг газар дээр нь хэвлэж олгон, зөвлөгөө мэдээллийг 23 иргэнд өгсөн, харин Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 4 бүртгэл хийж, 19 иргэнд зөвлөгөө мэдээлэл тус тус өгч ажиллалаа. "Бөмбөгөр 100" унадаг дугуйн тэмцээнд Улсын бүртгэлийн хэлтэс-Монгол банкны баг тамирчид хамтран оролцсон ба баг тамирчид 2 дугаарт байрт шалгарлаа.



Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллого зохион байгуулагдаж байгаатай холбоотойгоор хэлтсийн дарга тооллогын комисст орж ажилласан. Сумдын бүртгэгч нарт хэлтсийн даргын 2022 оны 05 сарын 09-ний өдрийн 1/446 тоот албан бичгээр Төрийн байгууллагуудын хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг тогтоосон хугацаанд бүртгүүлэх арга хэмжээ авч зохион байгуулах талаар чиглэл хүргүүлсэн мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах ажлын хүрээнд Орон нутгийн өмчийн газартай хамтран Төрийн байгууллагуудын хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөлт, хаяг, удирдлага өөрчлөлтийн бүртгэлийг эрчимжүүлэн зохион байгуулав.

- Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс 3,10 дугаар саруудад зохион байгуулсан төрийн албан хаагчийн шалгалтын комисст ажиллан, шалгалтанд оролцогчдын мэдээллийг хурууны хээгээр шалган оруулж хамтран ажиллалаа.

-Аймгийн ЗДТГ-аас 7 хоног бүрийн Мягмар гарагт зохион байгуулагддаг байсан шуурхайг 14 хоногт нэг удаа зохион байгуулж байгаа ба тус шуурхай мэдээллийн цагт хэлтсийн дарга бүрэн хамрагдаж албан хаагчдад мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэн ажиллав.

-Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Хяналт шинжилгээ үнэлгээний үр дүнг дээшлүүлэх нь” сургалтанд оролцсон Баянхонгор аймгийн бүх сумдын ЗДТГ-ын дарга, ЗДТГ-ын дотоод ажил, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, сумын нотариатын үүрэг гүйцэтгэгч нарт “Нотариатын үйлдэл улсын бүртгэлд нөлөөлөх нь” сэдвийн хүрээнд Улсын бүртгэлийн багц хуульд орсон зарчмын томоохон өөрчлөлт, улсын бүртгэлийн зорилго, ач холбогдол, үр нөлөө, Хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой гэрээ, хэлцлийг гэрчлэх нотариатын үйлдэл хийхдээ анхаарах зүйл, нотариатын хууль зүйн шаардлага хангаагүй үйлдэл, гэрчилсэн гэрээ хэлцлийн үр дагавараас хамаарч улсын бүртгэл хүчингүй болох нөхцөл зэрэг асуудлыг хөндсөн нэн хэрэгцээт сургалтыг хийхийн зэрэгцээ Улсын бүртгэлийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа улсын бүртгэлийн цахим үйлчилгээ болон иргэний тоон гарын үсгийн талаар цаг үеийн мэдээ, мэдээллийг хүргэж, нийгмийг манлайлан улсын бүртгэлийн цахим үйлчилгээний идэвхитэй хэрэглэгч болохыг уриаллаа.



-Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Аялгуу ресторанд зохион байгуулсан Залуучуудын зөвлөлийн чуулга уулзалтанд хэлтсийн 3 албан хаагч оролцов.



УИХ-ын даргын чиглэл болгосноор 06 сарын 29-ний өдөр Баянхонгор аймагт зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагын зөвлөгөөн”-д хэлтсээс 3 албан хаагч Тэмүжин театрт оролцов.

-2022 оны 07 сарын 29-31-ний өдрүүдэд Баянхонгор аймаг байгуулагдсаны 70 жилийн ойн Баяр наадам зохион байгуулагдсан бөгөөд тус наадмын бэлтгэл зохион байгуулалтын ажлын хүрээнд **Улсын бүртэлийн хэлтэс** “Зочид төлөөлөгчдийг угтах” хэсэгт хуваарилагдан ажиллаж хамт олноороо 2022 оны 07 сарын 26-ны өдөр аймаг руу орох замд орших Өлзийт суманд байрлах Цагдаагийн пост орчмын хог хаягдлыг цэвэрлэн, Зочидыг угтах гэрийг барьж тохижуулав. Улмаар 07 сарын 27-29-ний өдрүүдэд ойн арга хэмжээнд хүрэлцэн ирж буй нийт 250 гаруй зочидыг угтан авч хүндэтгэл үзүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж ажиллалаа. Хамт олныхоо хүчээр хийсэн ажлыг үнэлж Ойн баяр наадмын комиссын зүгээс 1 ямаа, 1 хонийг хэлтсийн сүрэгт бэлэглэсэн юм.



Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран “Иргэний оршин суух бүртгэл цахимжлаа” мэдээллийн өдөрлөг 2022 оны 09 дүгээр сарын 16-18-ны хооронд зохион байгуулагдаж Баянхонгор сумын иргэний улсын бүртгэгч оролцож, холбогдох тайлан мэдээг хүргүүлэв.




Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч С.Эрдэнэбат ахлагчтай ажлын хэсэг 9 сарын 28-ны өдөр Төрийн захиргааны албан хаагчдын цалин хөлс нэмэх, нэмэгдэл хөлс олгох, нийгмийн хамгааллыг баталгаажуулах ажлаар уулзалт хэлэлцүүлэг хийж хэлтсээс 6 албан хаагч оролцов.

-Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүд иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэх, олон шатлалт үйлчилгээг цогцоор нь авах боломжийг бүрдүүлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, тайлбарлан таниулах, шинэ тутам мэдээ мэдээлэл, хууль тогтоомжийг таниулан, зөвлөн туслах, иргэдийн санал хүсэлтийг газар дээр нь сонсох, асуудлыг шийдвэрлэх, өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцах зорилгоор "Төрийн үйлчилгээний өдөрлөг"-ийг 09 дүгээр сарын 26-30-ны хооронд аймгийн хэмжээний 19 суманд зохион байгуулав. Өдөрлөгийг тухайн сум орон нутагт зохион байгуулах 4 ажлын хэсэгт хэлтсийн 4 албан хаагч оролцож зөвлөгөө мэдээлэл өгөх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, улсын бүртгэлийн гэрчилгээг иргэдэд олгохын зэрэгцээ 499 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч гарын авлага материал тараасан. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 27, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 20, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 22 үйлчилгээ үзүүлж ажилласан.



-Аймгийн Засаг даргын захирамжаар зарлагдсан "Цахим байгууллага" аяны нээлтийг Улсын бүртгэлийн хэлтсээс эхлэн хийсэн бөгөөд 10 дугаар сарын 3-ны өдөр иргэд үйлчлүүлэгчдэд "Нээлттэй өдөрлөг"-ийг зохион байгууллаа. Энэ өдөр Гонгандан дэдлэн хийд болон аймгийн Цагдаагийн газрын хамт олон Тоон гарын үсгээ авлаа. Хэлтсээс Улсын бүртгэлийн үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл, тоон гарын үсгийн тухай ойлголт, бүртгэлийн байгууллагын цахимжилт зэрэг мэдээллийг өгч ажиллав. Мөн аяны хүрээнд аймгийн ЗДТГ-аас бүртгэлийн байгууллагаас үзүүлж буй цахим үйлчилгээг сурталчилж үйлчилгээг хэрхэн яаж авах, үйлчилгээ авахад ямар цаг хугацаа зарцуулж буй зэргийг газар дээр нь шууд бичлэг хийж монтажлан, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж олон нийтэд сурталчилж ажиллав.



МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний нээлтийн өдөрлөг Баянхонгор аймагт 10 дугаар сарын 2-5-ны өдрүүдэд зохион байгуулагдаж хэлтсийг төлөөлөн хэлтсийн дарга оролцов.

-“Төлөөлөгчийн нэг өдөр” арга хэмжээг зохион байгуулав.

Аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр аймгийн ИТХ-ын төлөөлөгч Б.Энхтүвшин, НБХ-ийн дарга Б.Наранбаярын хамтаар удирдамжид заасан дагуу тус хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж, албан хаагчидтай уулзалт хийн бидний санал хүсэлтийг сонсон цаашид анхаарах асуудлаар ярилцав. Тус арга хэмжээний хүрээнд хэлтсийн үйлчилгээний зааланд ажиллаж иргэд үйлчлүүлэгчдийн бүртгэлийн байгууллагатай холбоотой санал гомдлыг хүлээн авахын зэрэгцээ, төлөөлөгчийн эрх үүрэг, аймгийн ИТХ-аас хийж хэрэгжүүлсэн ажлын товч тайланг тус тус танилцуулав.

Хэлтсээс мөн тулгамдсан асуудлуудыг танилцуулж аймгийн ИТХ-ын төлөөлөгч Б.Энхтүвшинд 2022 оны 10 дугаар сарын 11- ний 1/853 тоот албан хүсэлтийг өгч, дэмжлэг хүслээ.

МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээнд хэлтсийн 10 албан хаагч оролцож холбогдох мэдээллүүдийг сонсож хэлэлцүүлэгт оролцов.

Иргэний андгай өргөх ёслолыг улс орон даяар 11 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан бөгөөд хэлтсээс 16 насанд хүрч цахим үнэмлэхээ гардан авах сурагчдын судалгааг гарган, цахим үнэмлэхийг гардуулж тангараг өргөх ажиллагаанд хэлтсийн дарга төлөөлөн оролцлоо.

АРВАН НЭГ. ХЭЛТСЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН БУСАД АЖИЛ

Албан хаагчдынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, холбогдох төлөвлөгөөний биелэлтийг хангах чиглэлээр 3 дугаар сарын 19-ний өдөр “Идэвхтэй хөдөлгөөн эрүүл амьдралын үндэс” явган аялал зохион байгуулж, “Дэмбээ мэдэх үү хө” амралтын газарт Мөсний шагай, хоккей, Амьтдын төлийг хэн сайн мэдэх вэ, Дует дууг хэн сайн дуулах вэ зэрэг тэмцээнүүдийг багуудын дунд зохион байгуулж явууллаа. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн баярыг тохиолдуулан хамтатган албан хаагчдын дунд Монета зарлаж бэлэг солилцдог уламжлалаараа энэ өдөр мөн бэлгээ солилцож бие биендээ урмын сайхан халуун

дулаан үгээ хэлж, хамтдаа өнгөрүүлсэн дурсамжит нэгэн өдөр нэгээр нэмэгдсэн юм.




2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр УБЕГ-аас Жендэрийн үндэсний хорооноос “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан “Би Жендэрийн хэвшмэл байдлын эсрэг байна” уриатай БИ... БАЙНА аяныг 2021 оны 03 дугаар сарын 15-наас 18-ны өдрүүдэд зохион байгуулсантай холбогдуулан БИ ... БАЙНА аяны лого бүхий зургийн хүрээгээр фэйсбүүк пэйж хуудсынхаа нүүр зургаа бүх албан хаагчид сольж уг аяныг дэмжин илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлсэн.



-НҮБ-ын Ерөнхий ассамблей 1993 оны есдүгээр сарын 20-ны хуралдаанаар 1994 оноос эхлэн тавдугаар сарын 15 өдрийг "Гэр бүлийн өдөр" болгох тогтоол баталсан байдаг. Энэ оны Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Баянлиг, Хүрээмарал, Бууцагаан, Өлзийт сумдын улсын бүртгэгч нар сумдын ЗДТГ-тай хамтран Гэр бүлийн үнэ цэнэ, бахархал, үүрэг хариуцлагыг ойлгуулах зорилгоор “Гэр бүлийн андгай өргүүлэх ёслол”-ын арга хэмжээг зохион байгуулжээ. Тус арга хэмжээний хүрээнд 35 гэр бүлийн 70 хос залуучуудыг Гэр бүлийн андгай өргүүлж, шинээр гэр бүл болсон 8 залуу хосын гэрлэлтийг бүртгэн гэрлэлтийн гэрчилгээ болон гэрлэлтийн тангаргыг ёслол төгөлдөр гардуулан өгч ажиллалаа.




-Хэлтсийн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос 1420000 төгрөг зарцуулж “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан хэлтсийн “Эцэг эхийн зөвлөл”-өөс санаачлан ирээдүй болсон хойч үе, үр хүүхдүүдийн дунд “АХА” болон бусад уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж, дурсгалын зүйл, гарын бэлгийг гардуулав.



-Байгууллагын албан хаагчдын дундын сангаас хүндээр өвчилсөн ажилтан түүний гэр бүлд тус тус 200,000 олгодог ба онд 1 албан хаагчид олгосон байна.

-Мөн УБЕГ-ын мэдээллийн технологийн инженер Лхагвасүрэнгийн гэр бүлд 835000, Хан -Уул дүүргийн улсын бүртгэгчийн гэр бүлд 200000 төгрөгийн хандивыг тус тус өргөлөө.

Хэлтсээс сайн үйлсийн аянд нэгдэж Баянцагаан суманд галын аюулд өртөн орон гэргүй болсон Г.Арьяабалын гэр бүлд сэтгэлийн хандиваа өргөн иргэдийн бичиг баримтын үнэ болон бусад мөнгөн дэмжлэгт нийт 800000 төгрөгийг хандивлав.



Тус аяны мэдээллийг байршуулснаар Баянцагаан сумын иргэний улсын бүртгэгчээс “Сайн үйлсийн аян бүтээлцсэн хамт олондоо баярлалаа. Бидний хийсэн үйлс бум түмээр арвижих болно. Бидэнд талархсан лайк, зүрх, халамж 213, коммент 71, шейр 15 хүрч явна. Дандаа л манай хамт олонд талархсан талархлын үгс байна. Сайхан энергитэй өдрийг хамт өнгөрөөсөн та бүхэндээ дахин дахин баярлалаа.” гэсэн талархал ирүүлсэн байна.

-Хэлтсийн хамт олноос санаачлан Баянхонгор аймаг байгуулагдсаны 70 жилийн ойн баяр наадмыг тохиолдуулан аймгийн төвийн сум болох Баянхонгор сумын



Оготной булаг орчимд байгуулагдаж буй спорт амралтын бүсэд иргэд амрах, салхилахад зориулан “Далай ээж” тавилгын үйлдвэрт Сүүдрэвчийг өөрсдийн хандиваар /2000000 төгрөг/ захиалан хийлгүүлж, байршуулж хүлээлгэн өгсөн нь бас нэгэн “Бүтээлч ажил” боллоо.

Улсын бүртгэлийн байгууллагын 82 жилийн ой, “Бүртгэлийн ажилтны өдөр”-ийг хэлтсийн даргын баталсан хөтөлбөрийн дагуу 2022 оны 11 дүгээр сарын 18-19-



ний өдрүүдэд зохион байгуулж эхний өдөр сургалт, хэлэлцүүлэг, дараагийн өдөр Спортын тэмцээн уралдааныг зохион байгуулж, Хүндэтгэлийн хүлээн авалтыг хийж шагнал урамшууллыг гардууллаа.

АРВАН ХОЁР. ИДЭВХ САНААЧИЛГА, ШИНЭЛЭГ АЖЛЫН ТАЛААР

Хэлтсээс ажилтнуудын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд өөрсдийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэх ажил буюу илтгэл мэдээлэл хийх, сэдэв сонгон хичээл заах, шинэлэг ажил санаачлан хэрэгжүүлэх зэрэг шаардлагуудыг тавьж батласнаар дараах ажлууд зохион байгуулагдлаа.

1.Баян-Өндөр сумын иргэний улсын бүртгэгч Д.Тансаг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан дагуу “Төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх нь”

сэдэвт хэлэлцүүлгийг хэлтсийн нэгдсэн сургалт семинарийн үеэр зохион байгуулж явуулсан нь маш чухал хэлэлцүүлэг болсон ба өөрийн ажлын туршлага, цаашид суралцах зүйлсийн талаар хамт олонтойтой санал бодлоо хуваалцсан арга хэмжээ боллоо. Д.Тансаг бүртгэгч нь тус өдрийн сургалтын үдийн цайг 200000 төгрөг



зарцуулан ивээн тэтгэсэн болно.

2.Хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо сумдад “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2022 оны 05 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж бүртгэлийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, цахимжилт, тоон гарын үсгийн талаар сурталчилж ажиллалаа.

Нээлттэй хаалганы өдөрлөгөөр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ 72, зөвлөгөө мэдээллийг 68, гарын авлага брошур 162 ширхэгийг тарааж, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр үндэсний гадаад паспортын бүртгэл 41, бусад бүртгэл 25, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 34, 355 иргэний тоон гарын үсгийн бүртгэлийг тус тус хийсэн байна.

Бүртгэлийн хяналтын чиглэлээр 5 сумын 158 бүртгэлд хяналт тавьж, иргэний үнэмлэхний хугацаа дууссан 4 зөрчлийг газар дээр нь шалгаж шийдвэрлэж, иргэдээс 7 өргөдөл, албан тушаалтнаас 1 хүсэлтийг шийдвэрлэн, E Mongolia -аар захиалаад ирээгүй 2 иргэний цахим үнэмлэхийн асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.

Мөн энэ үеэр сумдын дэлгүүрүүдэд иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалсан эсэхэд хяналт шалгалт хийхэд ийм зөрчил илрээгүй болно

3.Аймгийн ИТХ-ын ээлжит хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн шийдвэрээр Баянхонгор сумын иргэдийн хаягийн өөрчлөлтийг иргэний улсын бүртгэл мэдээллийн санд өөрчлөн тусгах ажлын бэлтгэлийг хангахаар гэрээт ажилтан авч ажиллуулах ажлын зардалд 15,5 сая төгрөг шийдвэрлүүлж Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй Баянхонгор сумын 6534 хаягийн жагсаалтыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газраас гаргуулан 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 2 дугаар сарын 07-ны өдрийн хугацаанд Улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь Баянхонгор сумын 1-р баг Номгон, 2-р баг Эрдэнэмандал, 3-р баг Дуурсах, 4-р баг Угалз, 5-р баг Цагаанчулуут, 6-р баг Гэгээншавь, 7-р баг Цахир, 9-р баг Есөнбулаг багийн хуучин хаягийг Баянхонгор аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, багийн засаг дарга, багийн бүртгэл мэдээллийн ажилтан нартай хамтран тулгалт хийж жагсаалтыг бэлтгэсэн.

2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 3 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Баянхонгор сумын газрын даамал Б.Нармандах, н.Сарангэрэл нартай хамтран 1-р баг Номгон, 2-р баг Эрдэнэмандал, 3-р баг Дуурсах, 4-р баг Угалз, 5-р баг Цагаанчулуут, 6-р баг Гэгээншавь, 7-р баг Цахир, 9-р баг Есөнбулаг багийн хаягийг газар дээр нь очиж дахин тулгалт хийв.

Мөн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй боловч иргэн бүртгэлгүй 189 байр, 108 гудамжны хаягийн судалгааг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж мэдээллийн санд хүчингүй болгосон.

Одоогоор Баянхонгор сумын 1-р баг Номгон, 2-р баг Эрдэнэмандал, 3-р баг Дуурсах, 4-р баг Угалз, 5-р баг Цагаанчулуут, 6-р баг Гэгээншавь, 7-р баг Цахир, 9-р баг Есөнбулаг багуудын иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь 5338 хаягийн мэдээллийг тулгалт үнэн зөв хийгдсэн эсэх талаар дахин хянаж ирүүлэхээр 2022.03.29-ний өдрийн 2/288 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч хариу ирээгүй байна. Дахин 2022.05.20-ны өдрийн 1/479 тоот албан бичгээр дээрх жагсаалтанд тусгагдсан хөрвүүлэх хаяг бичигдээгүй байгаа 435 хаягийн жагсаалтыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлснээр 2022 оны 11 дүгээр 15-ны 743 тоот албан бичгээр тулгалтыг хийн ирүүлснийг хяналтын улсын байцаагчдад

шийдвэр гаргуулахаар шилжүүлээд байна. Уг ажлын төлөвлөгөөний биелэлт 75 хувьтай байна.

4.Сумдын иргэний улсын бүртгэгч нарын дунд 2022 оны 03 дугаар сараас эхлэн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу **Шилдэг бүртгэгчийг** шалгаруулан алдаршуулж, дурсгалын зүйлийг гардуулан ажилтнуудынхаа идэвх санаачилга, ажиллах эрч хүч, урам зоригийг сэргээхэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулахад анхаарч ажиллалаа.

Удирдамжийн дагуу шалгаруулахад 3 дугаар сарын шилдэг бүртгэгчээр Бууцагаан сумын иргэний улсын бүртгэгч Б.Өлзийбаяр, 4 дүгээр сарын шилдэг бүртгэгчээр Богд сумын иргэний улсын бүртгэгч Д.Мягмар, 5 дугаар сарын шилдэг бүртгэгчээр Галуут сумын иргэний улсын бүртгэгч Ц.Ганчөдөр, 6 дугаар сарын шилдэг улсын бүртгэгчээр шалгарсан Баян-Өндөр сумын улсын бүртгэгч Доржийн Тансаг, 7 дугаар сарын шилдэг улсын бүртгэгчээр шалгарсан Баацагаан сумын улсын бүртгэгч Жалбуугийн Оргилмаа, II улирлын шилдэг улсын бүртгэгчээр шалгарсан Баянхонгор сумын улсын бүртгэгч Гришийн Бадамханд, 8 дугаар сарын шилдэг улсын бүртгэгчээр дахин Баацагаан сумын улсын бүртгэгч Жалбуугийн Оргилмаа, 9 дүгээр сарын шилдэг улсын бүртгэгчээр Жинст сумын улсын бүртгэгч Базардараагийн Тунгалаг, III улирлын шилдэг улсын бүртгэгчээр Өлзийт сумын улсын бүртгэгч Цэрэнпилийн Эрдэнэчимэг, 10 дугаар сарын шилдэг улсын бүртгэгчээр Шинэжинст сумын улсын бүртгэгч Базаррагчаагийн Баатаржав, 11 сарын шилдэг улсын бүртгэгчээр Жаргалант сумын улсын бүртгэгч Тайванжаргалын Алтаншагай нар тус тус шалгарч дурсгалын зүйлээр шагнаж, хэлтсийн вэйб хуудас, фэйсбүүк цахим хуудсуудаар шалгарсан тухай зурагт хуудсуудыг олон нийтэд түгээн баяр хүргэсэн нь маш олон хандалтуудыг авч байгаа нь тэдэнд урам зориг, илүү их эрч хүчийг өгсөн ажил болж байгааг хамт олноороо шагшин сайшааж байна.



-УБЕГ-аас 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III баримт бичгийн хүрээнд 2022 онд УБЕГ-аас авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан ирүүлснийг хэрэгжүүлж байна. Төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх ажлын хүрээнд хэлтсийн Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк хуудас болон Bayankhongor@burtgel.gov.mn вэйб сайтад 10 сараас эхлэн гадаад паспорттой холбоотой мэдээлэл 5 удаа, нээлттэй ажлын байрны зар 1 удаа кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтлээд байна. Мөн Төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх ажлын хүрээн хэлтсийн хаяг болон ажилтнуудын өрөө тасалгааны хаягийг монгол бичгээр үйлдэж байршуулаад жил гаруй хугацаа өнгөрчээ.

-УБЕГ-ын даргын шуурхай хурлаас 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр өгөгдсөн үүрэг даалгаврын **4. Албан хаагчдыг чадавхжуулах, хөрвөх чадвартай улсын бүртгэгч бэлтгэх сургалтыг тогтмол зохион байгуулах** гэсэн дагуу хэлтсийн даргаас 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Сургалтын төлөвлөгөө батлан хэрэгжүүлж эхлэв. Өнөөдрийн байдлаар сургалт 5 дахь удаагаа зохион байгуулагдсан байна. Хэлтсийн төвийн албан хаагчид танхимаар, сумдын албан хаагчид онлайнаар суралцаж байна.

-Баянхонгор аймгийн Алгоритм сургуультай хамтран 10 дугаар ангийн сурагчид ирээдүйн мэргэжилээ судлан сонгох ажлын хүрээнд "Мэргэжил бүхэн сайхан" уриан дор Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа, бүртгэгчийн нэг өдөртэй танилцах аялалыг зохион байгуулав. Бүртгэлийн байгууллагын үйлчилгээний онцлог, бүртгэлийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, цахимжилтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.

-УБЕГ-аас **Гэрэгэ киоскийг байршуулах аймагт хамрагдсан боловч одоогийн байдлаар байршуулаагүй байна.** Харин хэлтсээс Төрийн банкинд 2022 оны 10 сарын 04-ний өдрийн 1/826 тоот албан хүсэлт тавьж 2022 оны 11 дүгээр 1-ий өдрөөс эхлэн бүртгэлийн үйлчилгээний хураамжийг пос машинаар авч эхлэснээр иргэд олон дахин явахгүй байх нөхцлийг бүрдүүлээд байна.

Бүртгэлийн байгууллагад олон жил үр бүтээлтэй, идэвх санаачилгатай, тогтвор суурьшилтай ажиллаж өөрийн хувь нэмрээ оруулан байгаа ажилтнуудаа тодорхойлж, урам зоригийг нэмэгдүүлж ажиллах эрч хүч өгөхөөр энэ онд "Улсын

бүртгэлийн Тэргүүний ажилтан цол” тэмдгээр Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд ахлах бүртгэгч У.Золзаяа, иргэний улсын бүртгэгч Ц.Сүнжидмаа, Г.Бадамханд, Б.Тунгалаг нар, УБЕГ-ын “Жуух бичиг”-ээр иргэний улсын бүртгэгч С.Болор-Эрдэнэ, Ж.Оргилмаа, Т.Алтаншагай, А.Оюунсүвд нар тус тус шагнагдсан байна.

Энэ оны 3 дугаар сарын 3-ны өдөр ХЗДХ-ын сайдаар ахлуулсан ажлын хэсэг Баянхонгор аймагт ажиллаж салбарын байгууллагуудын үйл ажиллагааг газар дээр үзэж танилцаж тодорхой асуудлуудыг шийдвэрлэсэн.

Сайдаас хэлтсийн албан байрны нөхцөл байдлыг газар дээр нь үзэж танилцсанаар барилгын засварын ажил, архивын нягтруулсан шүүгээ, хэлтсийн албаны автомашиныг шинэчлэх асуудлуудыг шийдвэрлэхээр болж холбогдох албаны хүмүүст үүрэг өгч 2023 оны төсвийн төсөлд байрны их засварын ажил тусгагдсан боловч Төрийн хэмнэлтийн хуулийн үйлчлэлээр эцэслэгдэн батлагдаагүй.

Хэлтсийн албан хаагчид хүйтэн сэрүүний улиралд албан байрандаа ч албаны унаандаа ч даарч хөрсөн байдалтай төрийн ажил үйлчилгээг түргэн шуурхай хүргэхийн төлөө бие сэтгэлээ зориулан, шантралгүй, гомдлолгүй ажиллаж байгааг дахин тэмдэглэе....

Тус ажлын хэсэгт Улсын бүртгэлийн Ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан ажилласан бөгөөд Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчидтай уулзалтыг хийж байгууллагын бодлого, үйл ажиллагааг танилцуулан хамт олны цаашдын ажил, амьдралд сайн сайхныг хүсэн ерөөж дурсгалын зураг авахуулсан дурсгалын зураг татуулав.



ДҮГНЭЛТ, САНАЛ

Улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг баримтлан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Хэлтсийн албан хаагч, сумдын улсын бүртгэгч нараар дамжуулан бүрэн эрхээ хэрэгжүүлж, 2022 оны үндсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. Дараах саналыг хүргүүлж байна.

Бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг хангах талаар

1.1 Бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж шинэчлэлт хийгдсэн боловч сүлжээний доголдол тасалдал байнга үүсэж байгаа тул найдвартай байдлыг хангах арга хэмжээг авах

1.2 Бүртгэлийн архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад анхаарч орон нутгийн хэлтсүүдэд нягтруулсан шүүгээ, хадгаламжийн нэгжийн хамгаалалтын хайрцаг /A4/ бэлтгэн нийлүүлэх

1.3 Байгууллагын архивыг нягтруулсан шүүгээгээр хангах

2. Албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшсэн тогтвортой байлгах талаар

2.1 2022 он гарсаар хүргүүлсэн холбогдох журманд заасан болзол хангасан ажилтнуудын зэрэг дэвийн нэмэгдлийг шийдвэрлэх;

2.2 Хөдөлмөрийн дотоод журманд заасан тусламж дэмжлэгийг тогтоосон хэмжээгээр олгоход шаардагдах төсвийг бүрэн тусган батлуулах ;

2.3 УБЕГ-аас дүүрэг, аймгуудын хэлтсүүдийн ажилтнуудын туршлага солилцох сургалт семинарыг бүсчилж зохион байгуулах

Эдгээр саналыг анхааран шийдвэрлэх нь байгууллага, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сайжруулах, бүртгэлийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөл боломжийг бий болгоход ач холбогдолтой байх болно.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.МӨНХЖАРГАЛ